

(18)

НЯЛГА-XVI ГЭРЭЭТ ТАЛБАЙН ТАЛААР
АШИГТ МАЛТМАЛ, ГАЗРЫН ТОСНЫ ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР,
КАНАД УЛСЫН “ШАМАН РЕСУРСЭС ЛТД” КОМПАНИЙН
ХООРООНД БАЙГУУЛСАН
БҮТЭЭГДЭХҮҮН ХУВААХ ГЭРЭЭ

2007 оны 7 дүгээр сарын 18-ны өдөр

ЭХ СУРВАЛЖ: WWW.ILTODGEREE.MN

БҮТЭЭГДЭХҮҮН ХУВААХ ГЭРЭЭ

Энэхүү Бүтээгдэхүүн хуваах гэрээг нэг талаас Ашигт малтмал, газрын тосны хэрэг эрхлэх газар /цаашид АМГТХЭГ гэнэ/, негөө талаас Қанад Улсын “Шаман Ресурсес Лтд” компани /цаашид Гэрээлэгч гэнэ/-ийн хооронд. ~~Оны 4 дүгээр сарын 18-ний өдөр~~ байгуулав.

ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

Энэхүү гэрээний зорилго нь Гэрээлэгч болон АМГТХЭГ-ын хоорондын харилцааг зохицуулахад оршино. АМГТХЭГ нь Монгол Улсын Засгийн газрын нэрийн өмнөөс Монгол Улсын нутаг дэвсгэрт газрын тостой холбогдсон үйл ажиллагаа явуулах тухай гэрээ байгуулж, түүний биелэлтэд хяналт тавих эрх бүхий байгууллага юм.

Гэрээлэгч энэхүү Гэрээ хэрэгжих хугацаанд Гэрээт талбайд газрын тостой холбогдсон үйл ажиллагаа явуулах онцгой эрхийг эдэлнэ.

Монгол Улсын иргэдэд өмчлүүлснээс бусад газар, газрын хэвлэй нь төрийн өмч байх бөгөөд Монгол Улс өөрийн ард түмний ашиг сонирхолд нийцүүлэн байгалийн неөц баялгаа хуульд заагдсаны дагуу гадаад улсын иргэн болон хуулийн этгээдүүдэд тусгай зориулалт, тодорхой хугацаа, болзолтойгоор ашиглуулна.

НЭГДҮГЭЭР ЗҮЙЛ

ТӨЛӨӨЛӨГЧИД

1.1. ТӨЛӨӨЛӨГЧ ТОМИЛОХ

- Монгол Улсын Засгийн газар нь энэхүү Гэрээний дагуу Засгийн газрын төлөөлөгчөөр АМГТХЭГ-ын даргыг болон түүний эрх олгосон төлөөлөгчийг томилж байна.
- Гэрээлэгч энэхүү Гэрээг хэрэгжүүлэх өөрийн төлөөлөгч (Гэрээлэгчийн төлөөлөгч)-өөр “Шаман Ресурсес Лтд” компанийн ерөнхийлөгч Жорж Стубосыг томилж байна.
- Засгийн газрын төлөөлөгч болон Гэрээлэгчийн төлөөлөгчийг энэхүү Гэрээний 23 дугаар зүйлд заасны дагуу негөө талдаа мэдэгдсэн үндсэн дээр өөрчилж болно.

1.2. ЗАСГИЙН ГАЗРЫН ТӨЛӨӨЛӨГЧИЙН НЭВТРЭХ ЭРХ

- Засгийн газрын төлөөлөгч (эсвэл Засгийн газрын төлөөлөгчийн томилсон эрх бүхий этгээд) нь шаардлагатай үед зохих мэдэгдлийн үндсэн дээр гэрээт талбайд нэвтрэх болон газрын тостой холбогдсон бүхий л үйл ажиллагаатай танилцах эрхтэй. Гэрээлэгч нь Засгийн газрын төлөөлөгчийг энэхүү эрхээ хэрэгжүүлэх боломжоор хангана.
- Монгол Улсын орон нутгийн засаг, захиргаа болон бусад эрх бүхий засгийн газрын байгууллагууд Гэрээлэгчийн газрын тостой холбогдсон үйл ажиллагаа явуулж буй талбайд холбогдох хууль, тогтоомжийг мөрдүүлэх шаардлагын хүрээнд нэвтрэх эрхтэй.

ХОЁРДУГААР ЗҮЙЛ

ТОДОРХОЙЛОЛТУУД

2. НЭР ТОМЬЁО

Дараах тодорхойлогдсон нэр томъёонууд хэрэв тухайн тохиолдолд өөрөөр тайлбарлаагүй бол энэхүү 2 дугаар зүйлд заасан агуулгатай байна.

“Бүртгэл тооцооны журам” гэж Хавсралт В-д заасан тайлан тооцоо хийх журмыг хэлнэ.

“Үнэлгээний талбай” гэж үнэлгээний хөтөлбөрийн дагуу үнэлгээ хийх нь зүйтэй гэж Гэрээлэгчийн үзсэн геологийн нэг буюу хэд хэдэн бүтэц буюу илрэлийг хэлнэ.

“Үнэлгээний хөтөлбөр” гэж үр ашигтай нээлт мөн эсэхийг тодорхойлох зорилгоор Нээлтийг үнэлэн тодорхойлоо Гэрээлэгчийн гаргасан ажлын хөтөлбөр, төсвийг хэлнэ.

“Дагалдах байгалийн хий” гэж газрын тостой холбогдон гарч болох эсвэл газрын тосыг олборлоход дагалдах аливаа байгалийн гаралтай хийг хэлнэ.

“Дагалдах бодис” гэж газрын тос ба байгалийн хийгээс гаргаж болох буюу тэдгээрийг дагалдан илэрсэн бусад бодисыг хэлнэ.

“Баррель” гэж 1,01325 барын агаарын даралтын дор Фаренгейтын жаран (60) хэмийн дулаанд буй буюу тийм нөхцөлд тааруулсан 158,987 литрийн хэмжээг хэлнэ.

“Төсөв” гэж мөнгөн хөрөнгийн орлого, зарлагын төлөвлөгөөг хэлнэ.

“Хуанлийн сар” гэж аргын тооллын арван хоёр (12) сарын нэг (1) нь бөгөөд энэ нь тухайн сарын эхний өдрөөс эхлэн, сүүлчийн өдрийг дуустал үргэлжилнэ.

“Хуанлийн улирал” гэж а/.нэг, хоёр, гурав дугаар сарууд; б/. дөрөв, тав, зургаа дугаар сарууд; в/. долоо, найм, есдүгээр сарууд; г/. арав, арваннэг, арванхоёр дугаар сарууд зэрэг аргын тооллын улирлын нэгийг хэлнэ.

“Хуанлийн жил” гэж аргын тооллын 1 дугээр сарын 1-нд эхэлж, 12 дугаар сарын 31-нд дуусах нэг (1) жилийг хэлнэ.

“Үр ашигтай нээлт” гэж газрын тосны геологи-геофизикийн хайгуул, мэдээлэл, олборлолт, тээвэрлэлт, борлуулалтын зардал, зах зээл, бусад техник эдийн засгийн бүх хүчин зүйлийг харгалзан үр ашигтайгаар олборлох боломжтой гэж Гэрээлэгчийн тогтоосон газрын тосны нөөцийг хэлнэ.

“Гэрээ” гэж гэрээт талбайд газрын тостой холбогдсон үйл ажиллагаа явуулахаар АМГТХЭГ болон Гэрээлэгчийн хооронд байгуулсан Гэрээг хэлнэ.

“Гэрээт талбай” гэж Хавсралт А, Б-д тодорхойлсон талбайг хэлэх бөгөөд энэ талбай нь 7 дугаар зүйлийн дагуу буцааж өгөх хэмжээгээр тухай бүр багасч байна.

“Гэрээт түүхий тос” ба “гэрээт байгалийн хий” гэж энэхүү Гэрээний дагуу гэрээт талбайгаас олборлож хуримтлуулсан түүхий тос ба байгалийн хийг хэлийн Уг нэр томъёог тайлбарлах үүднээс “олборлосон” гэдэг нь газрын хэвлийгээс гарган бүтээгдэхүүн хуваах хэмжүүрийн хэрэгслэлээр нэвтрүүлсэн, “хуримтлуулсан” гэдэг нь Гэрээнд оролцогч талууд харилцан тохиролцож, авч борлуулах боломжийг бүрдүүлсэнийг хэлэх бөгөөд харин:

1. гэрээт талбайн хүрээнд гадаргууны доорхи давхарга руу шахаж оруулсаныг;
2. дамжуулах хоолой дүүргэхэд ашигласныг;
3. газрын тостой холбогдсон үйл ажиллагааны явцад (шаталт, гоожилт, хаталт, ууршилт, осол буюу бусад эдгээртэй адилтгах байдлаар) алдагдсаныг тооцохгүй.

“Гэрээт жил” гэж Гэрээ хүчин төгелдөр болсон өдөр буюу дараагийн жилүүдийн уг өдрөөс эхлэн тооцсон дараалсан хуанлийн арван хоёр (12) сарын хугацааг хэлийн.

“Ашигт малтмал, газрын тосны хэрэг эрхлэх газар” гэж Монгол Улсын Засгийн газраас газрын тостой холбогдсон үйл ажиллагаа явуулах тухай гэрээ байгуулах, түүний биелэлтэд хяналт тавих эрх олгосон байгууллагыг хэлийн.

“Гэрээлэгч” гэж тус улсын нутаг дэвсгэрт газрын тостой холбогдсон үйл ажиллагаа явуулах талаар ашигт малтмал, газрын тосны хэрэг эрхлэх газартай гэрээ байгуулсан Монгол Улсын болон гадаад улсын иргэн, хуулийн этгээдийг хэлийн.

“Өртөгт тос” гэж 8.3 дугаар зүйлд заасныг хэлийн.

“Түүхий тос” гэж газар доорхи байгалийн агууламжид байгаа, эсвэл гадаргуу дээр ялгагч болон боловсруулах төхөөрөмжөөр оруулан гаргасны дараа агаарын даралтад шингэн байдалд буй нүүрс-устөрөгчийг хэлийн. Түүнчлэн “түүхий тос” гэсэн нэр томъёонд байгалийн барагшин, конденсат ба ялгагч үйлдвэр, эсвэл боловсруулах бусад төхөөрөмжид шингэрүүлсэн байгалийн шингэн хий багтана.

“Олборлолтын талбай” гэж 5.4 зүйлийн б-д заасныг хэлийн.

“Олборлолтын зардал” гэж олборлолтын үйл ажиллагаатай холбогдон гарах бүх зардал (үйл ажиллагааны болон хайгуулын зардлаас бусад)-ыг хэлийн.

“Олборлолтын үйл ажиллагаа” гэж нэг буюу түүнээс дээш тооны үр ашигтай нээлттэй холбоотой бүхий л үйл ажиллагааг хэлэх бөгөөд үүнд дараах үйл ажиллагаа багтана:

1. олборлолтын болон хайгуулын цооног өрөмдөх, дамжуулах хоолой, хадгалах сав, бусад байгууламж барьж байгуулах, ажиллуулах;
2. газрын тос ялгах, баяжуулах, уснаас ялгах, шахах, шингэрүүлэх, хадгалах, халаах, хий шатаах, тээвэрлэх болон бусад байдлаар боловсруулж ашиглах;
3. дахин шахаж эргэлт, даралтанд оруулах, олборлолтыг нэмэгдүүлэх хоёрдогч, туравдагч болон бусад үйл ажиллагаа;

“Олборлолтын хугацаа” гэж энэхүү Гэрээний 5.5 болон 5.7 дугаар зүйлд заасны дагуу олборлолтын үйл ажиллагаа явуулах хугацааг хэлийн.

“Олборлолтын толевлогоо” гэж үр ашигтай нээлттэй холбогдуулан явуулах олборлолтын үйл ажиллагааны Ажлын хотгэлбор, төсвийг хэлийн.

“Нээлтийн цооног” гэж Гэрээлэгч газрын тосны агууламж илрүүлж, үүнд цаашид үр ашигтай нээлт агуулах эсэхийг нь тогтоох зорилгоор туршилт, үнэлгээ хийх шаардлагатай гэж тодорхойлсон цооногийг хэлнэ.

“Гэрээ хүчин төгөлдөр болсон одор” гэж энэхүү Гэрээг Монгол Улсын Засгийн газар баталсан өдрийг хэлнэ.

“Хайгуулын зардал” гэж хайгуулын үйл ажиллагаатай холбогдон гарсан бүх зардал (үйл ажиллагааны болон олборлолтын зардлаас бусад) -ыг хэлнэ.

“Хайгуулын үйл ажиллагаа”-нд дараах үйл ажиллагаа багтана:

1. агаарын болон гадаргуун зураглал, геологи, геофизик, геохимийн судалгаанууд, хайгуулын болон үнэлгээний цооног өрөмдөж ажиллуулах, эрдсийн болон давхарга зүйн судалгаа явуулах, хайгуулын мэдээллийн тайлал хийх болон дээрхтэй холбоотой бусад бүхий л үйл ажиллагаа;
2. үнэлгээний хөтөлбөр хэрэгжүүлэх.

“Хайгуулын хугацаа” гэж 5 дугаар зүйлд заасныг хэлнэ.

“ICC” гэж Олон улсын худалдааны танхим. /International Chamber of Commerce/

“Талбайн дэнчин” гэж Гэрээлэгч гэрээт талбайд газрын тостой холбогдсон үйл ажиллагаа явуулах онцгой эрх здэлснийхээ төлөө “Газрын тосны хуулийг хэрэгжүүлэх журам”-д заасны дагуу гэрээт талбайн хэмжээгээр Монгол Улсын Засгийн Газарт нехөн төлөгдөхгүйгээр төлөх төлбөрийг хэлнэ.

“Хууль” Монгол Улсын хэмжээнд хүчин төгөлдөр мөрдөгдөж буй бүх хууль, эрх зүйн акт болон цаашид батлагдан гарах хууль, эрх зүйн актыг хэлнэ.

“Хуулийн этгээд” гэж хуульд заасан журмаар хуулийн этгээд болох нь нотлогдсон аливаа аж ахуйн нэгжийг хэлнэ.

“Хэмжих цэг” гэж Энэхүү гэрээний хавсралт “Г” -ийн 4 дүгээр зүйлийн 1-ийн “в”-д тодорхойлсон ачих цэгийг хэлнэ.

“Наад захын зардлын хэмжээ” гэж Хавсралт В-д заасан ажил үүргийг гүйцэтгэхэд зарцуулах зардлын хэмжээг хэлнэ.

“Байгалийн хий” гэж агаарын даралт, температурын хэвийн нехцэлд хийн байдалд буй нүүрс-устерөгчийг хэлэх бөгөөд үүнд хүнд ба хөнгөн хий, газрын тосны олборлолтын хий болон, хүнд хийгээс шингэн нүүрс-устерөгчийг ялгаж авсан дараа үлдэх хий, түүнчлэн шингэн буюу хийжүүлсэн нүүрс-устерөгчтэй хамт гарган авсан бусад хий тус тус багтана.

“Үйл ажиллагааны зардал” гэж Гэрээлэгчийн газрын тосны үйл ажиллагааны явцад гарсан зардлыг хэлэх ба үүнд хайгуулын болон олборлолтын зардал орохгүй болно.

“Газрын тос” гэсэн ойлголтод газрын хэвлийд байгаа шингэн тос, хий болон хатуу байдалтай хамтад нь буюу дангаар нь олборлож болох нүүрс-ус төрөгчийн төрөл бүрийн нэгдлийг хамааруулна.

“Газрын тосны өртөг” гэж 8.3 дугаар зүйлийн а-д заасныг хэлнэ.

“Газрын тосны тухай хууль” гэж 1991 оны 2 дугаар сарын 13-ны өдөр хүчин төгөлдөр болсон Монгол Улсын Газрын тосны тухай хууль болон цаашид орох нэмэлт өөрчлөлт, шинэчлэн найруулсан хуулийг хэлнэ.

“Газрын тостой холбогдсон үйл ажиллагаа” гэсэн ойлголтод энэхүү Гэрээтэй холбогдуулж газрын тос хайх, хамгаалах, олборлох, боловсруулах, тээвэрлэх, хадгалах, борлуулах ажиллагааг хамааруулна.

“Хуваах тос” гэж гэрээт түүхий тосноос роялти болон өртөгт тосыг хассаны дараа үлдэх хэсгийг хэлнэ.

“Бүтээгдэхүүн хуваах хэмжилт” гэж 11.1 дүгээр зүйлд заасныг хэлнэ.

“Роялти” гэж Газрын тосны тухай хуулийн дагуу Монгол Улсын байгалийн нөхөн сэргээгдэшгүй баялгийг ашигласны төлбөрийг хэлэх бөгөөд роялтийг нийт Гэрээт түүхий тосноос тооцоолж төлнө.

“Туслан гүйцэтгэгч” гэж газрын тостой холбогдсон үйл ажиллагааны тодорхой хэсгийг гүйцэтгэхээр Гэрээлэгчтэй гэрээ хийсэн хуулийн этгээд юм.

2.2 ТАЙЛБАР

- a/ Гэрээний зүйлүүдийн гарчгийг зөвхөн ойлгоход хялбар болгох үүднээс нэрлэсэн бөгөөд энэхүү Гэрээний зүйл заалтыг тайлбарлахад ашиглахгүй.
- b/ Энэхүү Гэрээний тухайн заалтын хувьд ганц тоон дээр хэрэглэсэн үгүүдийг мөн олон тоон дээр, эсрэгээрээ олон тоон дээр хэрэглэсэн үгсийг ганц тоон дээр хамааруулан ойлгоно.
- v/ “бичсэн” болон “бичгээр” гэсэн ойлголт нь факсаар харилцсан мэдээллийг хамаарна.
- g/ Хэрэв өөрөөр тусгайлан заагаагүй бол энд дурдсан “зүйл” гэснийг энэхүү Гэрээний зүйл гэж ойлгоно.
- d/ Аливаа тал хэмээн энд дурдсан нь талуудын зөвшөөрсөн эрх залгамжилсан болон шилжүүлсэн этгээдэд мөн хамаарна.
- e/ “оролцуулах” гэдгийг “хязгаарлалтгүйгээр оролцуулах”, “оролцуулан” гэдгийг оролцуулан, гэхдээ үүгээр хязгаарлагдахгүйгээр” гэж ойлгоно.
- ë/ Энэхүү Гэрээний эх хувь болон Гэрээний Хавсралтыг тайлбарлахад зөрүү гарвал Гэрээ шийдвэрлэх хүчинтэй болно.

ГУРАВДУГААР ЗҮЙЛ

АМГТХЭГ БОЛОН ГЭРЭЭЛЭГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ

3.1. АМГТХЭГ-ЫН ЭРХ

АМГТХЭГ нь дараахь эрхтэй.

- а) Гэрээлэгчийн газрын тостой холбогдсон үйл ажиллагаанд хяналт шалгалт хийнэ.
- б) Геологи, геофизик, петрохими, геохими болон гэрээт талбайтай холбогдох бусад бүхий л мэдээллийн эх хувийг өмчилнэ.
- в) Гэрээлэгчийн явуулж буй бүх үйл ажиллагаатай холбогдсон баримт бичиг болон хэрэглэж буй тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, барилга байгууламжийн заавар, техникийн тодорхойлолт, зураг зэрэг техникийн баримт бичгийн хувийг авна.
- г) Гэрээлэгчээс түүний хуваарьт Газрын тосыг Монгол Улсын дотоодын хэрэгцээнд нийлүүлэхийг хүсэх эрхтэй бөгөөд энэ тохиолдолд үнэ, нөхцлийг харилцан тохиролцно.
- д) Монгол Улсын Засгийн газарт ногдох Газрын тосны борлуулалтад хяналт тавьж, захиран зарцуулна.
- е) Энэхүү гэрээнд заагдсан бусад эрхийг здэлнэ.

3.2. АМГТХЭГ-ЫН ҮҮРЭГ

АМГТХЭГ нь дараахь үүргийг хүлээнэ.

- а) Гэрээлэгчийн газрын тостой холбогдсон үйл ажиллагаа явуулахад Гэрээлэгчид дэмжлэг, туслалцаа үзүүлнэ.
- б) Газрын тостой холбогдсон үйл ажиллагаанд холбогдох хууль, тогтоомжийг хэрэгжүүлж, хяналт тавина.
- в) Гэрээлэгчид Монгол Улсын Засгийн газрын эзэмшиж байгаа дамжуулах хоолой, бусад тээвэрлэлт, экспорт, дэд бүтцийн байгууламжуудад нэвтрэхийг зөвшөөрнө.
- г) Газрын тостой холбогдсон үйл ажиллагааг цаг тухайд нь үр дүнтэй явуулахын тулд Гэрээлэгчийн хүсэлтээр Гэрээлэгчийг засгийн газар, бүс нутаг болон орон нутгийн засаг захиргааны байгууллагуудад танилцуулах ажлыг зохион байгуулах, эдгээр байгууллагуудтай харилцаад нь туслалцаа үзүүлнэ.
- д) Гэрээлэгчийг Гэрээт талбайд газрын тостой холбогдсон үйл ажиллагаа явуулахад сөргөөр эсвэл үндэслэлгүйгээр хөндлөнгөөс оролцох, саад учруулах, хойшлуулах аливаа үйлдлийн эсрэг Гэрээлэгчийг хамгаалж, урьдчилан сэргэжилүүлэх үүднээс өөрийн эрх мэдлийн хэмжээний бүхий л арга хөмжсөг авна.
- е) Гэрээлэгчийн хүснэгтээр дараахь бичиг баримтыг авахад тусална. Үүнд:

- i. Гэрээлэгчид газрын тостой холбогдсон үйл ажиллагааг үр ашигтай явуулахад нь Монгол Улсын нутаг дэвсгэр дэх Гэрээт талбай болон бусад талбайд нэвтрэхэд шаардлагатай бүхий л зөвшөөрөл, лиценз.
- ii. Газрын тостой холбогдсон үйл ажиллагааг үр дүнтэй явуулах үүднээс Монголын банкинд гадаад болон дотоод валютын данс нээх, хадгаламж хийх, гүйлгээ хийхэд шаардлагатай бүхий л зөвшөөрөл, лиценз.
- iii. Газрын тосны үйл ажиллагаатай холбогдуулан гүйцэтгэх шинжилгээ, боловсруулалт хийх баримт материал, өгөгдөл, дээжийг Монгол Улсын нутаг дэвсгэрээс гаргахад шаардлагатай бүх зөвшөөрөл.
- iv. Газрын тостой холбогдсон үйл ажиллагаанд ашиглагдах бүх тоног төхөөрөмж, бараа материалын лиценз.
- v. Гэрээлэгчид олгогдсон эрх, гүйцэтгэх шаардлагатай аливаа үйл ажиллагаа болон энэхүү Гэрээг үр дүнтэй хэрэгжүүлэх, Гэрээнд заасан газрын тостой холбогдсон үйл ажиллагааг явуулахад Монгол Улсын аливаа яам болон орон нутгийн засаг захирагааны бусад байгууллага, нэгжүүдээс шаардсан бусад бүх зөвшөөрөл, лиценз, эрхийн бичиг.

б) Гэрээлэгчийн хүснэгтээр дараахь асуудалд туслалцаа үзүүлнэ.

- i. Газрын тостой холбогдсон үйл ажиллагаатай холбогдон гарах тээвэрлэлт, дамжуулах хоолойн байгууламж болон бусад зарчмын чанартай асуудлыг шийдвэрлэх, мөн харилцаа холбооны төхөөрөмж сууринуулах зөвшөөрөл, орон сууц, эмнэлэгийн үйлчилгээ, албан газар, албан газрын шаардлагатай эд зүйлийг авах зөвшөөрөл,
- ii. Тоног төхөөрөмж, материал, сэлбэг хэрэгслийг хадгалах үүднээс газар, барилга байшин, болон агуулах байгууламж ашиглах эрхийг эзэмших,
- iii. Гадаад валют солих зөвшөөрөл авах,
- iv. Гаалийн дүрэм, бүх төрлийн гаалийн бүрдүүлэлт, импорт, экспортын зөвшөөрлийг авах,
- v. Газрын тостой холбогдсон үйл ажиллагаа явуулахад шаардлагатай телефон болон сансрын холбоо, радио шугам, долгионы гарц олж авах,
- vi. Газрын тостой холбогдсон үйл ажиллагаа явуулах шаардлагын улмаас Гэрээт талбайгаас гадна агаарын орон зайд нэвтрэх, ашиглах эрх авах,
- vii. Газрын тостой холбогдсон үйл ажиллагаа явуулах гадаадын ажиллагсадын Монгол Улсад нэвтрэх болон ажиллах зөвшөөрлийг авах,
- viii. Гэрээлэгчид олгогдсон эрх, гүйцэтгэх шаардлагатай аливаа үйл ажиллагаа болон энэхүү Гэрээг үр дүнтэй хэрэгжүүлэхтэй холбогдон гарах бусад асуудлууд.

3.3. ГЭРЭЭЛЭГЧИЙН ЭРХ

- a) Гэрээлэгч нь Монгол Улсын Газрын тосны тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжийн дагуу Гэрээт талбайд газрын тостой холбогдсон үйл ажиллагаа явуулах онцгой эрхийг эдэлж, газрын тостой холбогдсон үйл ажиллагааны оператороор ажиллана.
- б) Гэрээлэгч газрын тостой холбогдсон үйл ажиллагаа /ажиллагсадыг оролцуулан/ явуулах зохих зөвшөөрөл авах, Гэрээт талбайд болон талбайн гадна дамжуулах хоолой, гүүр, зам, орон сууц, агуулах байгууламж, нисэх онгоцны талбай, радио цамхаг, холбооны төхөөрөмж болон газрын тостой холбогдсон үйл ажиллагаанд



шаардлагатай бусад дэд бүтцийг барьж, байгуулах, нэвтрэх эрхтэй.

- в) Гэрээлэгч нь өртөгт тос болон өөрт ногдох хуваарьт тосыг захиран зарцуулах /Монгол Улсын нутаг дэвсгэрт болон хилийн чанадад/, тээвэрлэх, экспортлох эрхтэй.
- г) АМГТХЭГ-аас бичгээр зөвшеөрөл авсны үндсэн дээр Гэрээлэгч энэхүү Гэрээний эрх, ашиг сонирхолоо аливаа гуравдагч этгээдэд бүхлээр нь эсвэл тодорхой хэсгийг шилжүүлж болох бөгөөд шилжүүлэн авч буй гуравдагч этгээд нь олон улсад хүлээн зөвшеөрөгдсөн, санхүүгийн хангалттай эх үүсвэртэй, мэргэжлийн туршлагатай бол АМГТХЭГ нь зөвшеөрөл өгнө.
- д) Гэрээлэгч газрын тостой холбогдсон үйл ажиллагааны зарим хэсгийг Туслан гүйцэтгэгчид хариуцуулж болох боловч Гэрээлэгч үйл ажиллагаатай холбогдсон хариушлагаа бүрэн хүлээнэ.
- е) Гэрээлэгч газрын тостой холбогдсон үйл ажиллагааг явуулах шаардлагын улмаас Гэрээт талбай болон бусад талбайд чөлөөтэйгээр нэвтрэх, буцан гарах эрхтэй.
- ё) Гэрээлэгч газрын тостой холбогдсон үйл ажиллагааг илүү үр дүнтэй явуулах үүднээс оөрийн хүссэний дагуу үйлдвэр, тоног төхөөрөмж, бараа материалыа Монгол Улсын нутаг дэвсгэр дотор чөлөөтэй нүүлгэн шилжүүлэх эрхтэй.

3.4. ГЭРЭЭЛЭГЧИЙН ҮҮРЭГ

Гэрээлэгч нь газрын тостой холбогдсон үйл ажиллагааг явуулахдаа дараах үүргийг хүлээнэ:

- а) Монгол Улсын газрын тосны тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийг дагаж мөрднө.
- б) Газрын тостой холбогдсон үйл ажиллагааг Монгол Улсын олон улсын гэрээгээр хүлээсэн үүргийг зөрчихгүйгээр олон улсын газрын тосны салбарт хэвшсэн нийтлэг стандарт, журамд нийцүүлэн явуулна.
- в) Газрын тостой холбогдсон үйл ажиллагааг цагт нь бэлтгэн гүйцэтгэж байх бөгөөд олон улсын газрын тосны салбарын жишигт нийцсэн газрын тосын нөөцийг үр дүнтэй ашиглах техник, технологи, тоног төхөөрөмжийг хэрэглэнэ.
- г) Холбогдох хууль тогтоомжийн дагуу байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээг газрын тостой холбогдсон үйл ажиллагаагаа эхлэхээс өмнө заавал хийлгэсэн байна.
- д) Монгол Улсын хүн ам, ан амьтан, байгаль, үндэсний нөөц баялаг, газрын гадаргууг хамгаалах шаардлагатай дараах арга хэмжээ авна. Үүнд:
 1. Газрын тостой холбогдсон үйл ажиллагааны явцад хүн ам, байгаль орчин болон бусдын өмч хөрөнгийг хамгаалах, урьдчилан сэргийлэх арга хэмжээг холбогдох хууль тогтоомжийн дагуу олон улсын газрын тосны салбарт хэвшсэн нийтлэг стандарт, журамд нийцүүлэн авна.
 2. Гэрээний хугацаа дуусах, гэрээ хүчингүй болох, эсвэл гэрээт талбайгаас тодорхой хэсгийг буцааж огех тохиолдолд Засгийн газрын толөөлөгчийн

зөвшөөрсний дагуу бүх тоног төхөөрөмж, байгууламжийг талбайгаас гаргаж, Монгол Улсын холбогдох хууль, тогтоомжийн дагуу тухайн талбайн байгаль орчныг сэргээх шаардлагатай бүх арга хэмжээг авна.

3. Жил бүрийн ажлын хөтөлбөр, төсөвтөө хайгуулын цооногуудыг хаах, талбайн байгаль орчныг нехөн сэргээх зардлыг тусгах;
 4. Холбогдох хууль, тогтоомжоор газрын тостой холбогдсон үйл ажиллагаа явуулахыг хориглосон нутаг дэвсгэрийн ойр орчимд үйл ажиллагаа явуулах тохиолдолд тухайн гэрээт талбайн экологийн системийг хамгаалах, бохирдлоос сэргийлэхтэй холбогдсон тодорхой арга хэмжээ авч хэрэгжүүлэх;
- ж) Энэхүү Гэрээний 12 дугаар зүйлд заасны дагуу Гэрээний үргэлжлэх хугацаанд олж хуримтлуулсан геологи, геофизик, геохимийн судалгаа, өрөмдлөг, олборлолт, лабораторийн шинжилгээ болон бүх анхдагч мэдээлэл, тайланг зх хувиар нь АМГТХЭГ-т хүлээлгэн өгнө.
- з) Энэхүү Гэрээний 10.2 зүйлд заасны дагуу Монгол Улсын газрын тосны салбарын боловсон хүчин бэлтгэхэд дэмжлэг үзүүлиэ.
- к) Холбогдох хууль, тогтоомжийг зөрчсөний улмаас гарах бүх хохирлыг хариуцна.

ДӨРӨВДҮГЭЭР ЗҮЙЛ

ЗАРДАЛ

Гэрээнд өөрөөр заагаагүй бол газрын тостой холбогдсон үйл ажиллагаа явуулахад шаардагдах бүх зардлыг Гэрээлэгч хариуцна. Гэрээлэгч нь газрын тосыг үр ашигтай олборлож эхэлсэн нехцөлд 8.3 дугаар зүйлд заасны дагуу газрын тостой холбогдсон үйл ажиллагаа явуулсан зардлаа нехөж авах эрхтэй. Гэрээнд оролцогч аль ч тал үр ашигтай нээлт болно гэсэн баталгаа гаргахгүй бөгөөд Гэрээлэгч нь энэхүү Гэрээний дагуу зарцуулсан аливаа зардлыг нехөж авна гэсэн баталгаа байхгүй болно.

ТАВДУГААР ЗҮЙЛ

ХУГАЦАА

5.1. ХАЙГУУЛЫН ХУГАЦАА

- а) Хайгуулын ажил явуулах хугацаа нь Гэрээ хүчин төгөлдер болсон өдрөөс эхлэн таван (5) жил байх бөгөөд 3 үе шатад ангилна. Нэгдүгээр үе шат нь 2 жил, хоёрдугаар үе шат нь 1 жил, гуравдугаар үе шат нь 2 жил байна.

5.2. ХАЙГУУЛЫН ХУГАЦААГ СУНГАХ

- а) Гэрээлэгч хайгуулын 3 дугаар үет шат болон хайгуулын эхний сунгалтын хугацаа дуусахаас 30 хоногийн өмнө хайгуулын хугацааг цаашинд 2 жилийн хугацаагаар сунгуулах хүснэгтэйгээ Засгийн газрын төлөөлөгчид бичигээр мэдэгдэнэ.

- б) Гэрээлэгч нь хайгуулын хугацааг сунгах хүсэлт тавихдаа өмнөх хайгуулын үе шатны хайгуулын ажлын наад захын ажил үүргээ биелүүлсэн тохиолдолд АМГТХЭГ-аас Гэрээлэгчийн хүсэлтийн дагуу хайгуулын хугацааг сунгана.
- в) Хэрэв хайгуулын эцсийн хугацаа дуусгавар болох өдөр хүртэл үр ашигтай нээлт болох эсэх нь тодорхойгүй нээлтийн цооног байгаа бол уг нээлтийн цооног бүхий үнэлгээний талбайн хувьд нэмэгдэл хайгуулын хугацаа нь дараах нөхцөлүүдийн аль нэг нь болох хүртэл хүчин төгөлдөр үргэлжилнэ. Үүнд:
1. тухайн нээлтийг үр ашигтай нээлт гэж тогтоох,
 2. тухайн нээлтийг үр ашигтай бус нээлт гэж тогтоох,
 3. нэмэгдэл хайгуулын хугацаа нь нэг (1) жилээс илүүгүй байна.

5.3. НЭЭЛТ, ТУРШИЛТ БОЛОН ҮНЭЛГЭЭНИЙ АЖИЛ

- а) Нээлтийн цооног тогтоосон тохиолдолд Гэрээлэгч арван таван (15) хоногийн дотор Засгийн газрын төлөөлөгчид бичгээр мэдэгдэх бөгөөд тухайн мэдэгдсэн өдрийг уг нээлтийн цооногийг бүртгэсэн өдөрт тооцно.
- б) Нээлтийн цооног бүрийг бүртгэсэн өдрөөс хойш ер (90) хоногийн дотор Гэрээлэгч тус Нээлт нь Үр ашигтай нээлт мөн эсэхийг тогтоох үнэлгээний хөтөлбөр ба төсөв, үнэлгээ хийгдэх талбай (үнэлгээний талбай)-н зураг, бусад тодорхойлолтыг Засгийн газрын төлөөлөгчид гаргаж өгнө.
- в) Засгийн газрын төлөөлөгч үнэлгээний хөтөлбөрийг баталсаны дараа Гэрээлэгч Үнэлгээний хөтөлбөрийг хэрэгжүүлж эхэнэ.
- г) Үнэлгээний хөтөлбөрийг зуун ная (180) хоногийн дотор хэрэгжүүлнэ.

5.4. ҮР АШИГТАЙ НЭЭЛТ

- а) Үнэлгээний хөтөлбөрийг хэрэгжүүлж дууссан, эсвэл нэг болон түүнээс дээш Нээлтийн цооногууд нь Үр ашигтай нээлт гэж тогтоогдвол Гэрээлэгч арван таван (15) хоногийн дотор Засгийн газрын төлөөлөгчид бичгээр мэдэгдэх бөгөөд тухайн мэдэгдсэн өдрийг уг Үр ашигтай нээлтийг бүртгэсэн өдөрт тооцно.
- б) Үр ашигтай нээлт нэг бүрийг бүртгэсэн өдрөөс хойш нэг зуун наян (180) хоногийн дотор Гэрээлэгч нь Засгийн газрын төлөөлөгчид олборлолтын хөтөлбөр, төсөв, олборлолтын үйл ажиллагаа явуулах талбай (олборлолтын талбай)-н зураг, тогтоосон нөөц, олборлолтын талбайн зөвшөөрөл авахтай холбогдсон бусад тодорхойлолтыг гаргаж өгнө.
- в) Ашигт малтмал, газрын тосны хэрэг эрхлэх газар 5.4 дүгээр зүйлийн б-д заасан олборлолтын хөтөлбөр, төсвийг хулээн авсан өдрөөс хойш гуч (30) хоногийн дотор хянаж, холбогдох хууль, тогтоомж болон олон улсын газрын тосны салбарт хэвшсэн нийтлэг стандарт, журмыг зөрчөөгүй гэж үзвэл ер (90) хоногийн дотор олборлолтын төлөвлөгөө, төсвийг баталж, газрын тос олборлох тухай шийдвэр гаргана. Дээр дурдсан стандартыг зөрчсөн гэж үзвэл АМГТХЭГ-аас олборлолтын хөтөлбөр, эсвэл Олборлолтын талбайд нэмэлт, өөрчлөлт оруулахыг шаардах бөгөөд эдгээр нэмэлт, өөрчлөлтүүд нь зөвхөн Олборлолтын төлөвлөгөө эсвэл Олборлолтын талбайг стандартын дагуу болгох, мөн Гэрээлэгчийн газрын тостой холбогдсон үйл ажиллагааны үр дүн, эдийн засгийн ашиг тусад хамгийн бага сөрөг нелеөтэй байхад чиглэгдэнэ.

- г) Гэрээлэгч нь Газрын тос олборлох тухай шийдвэр гарсан өдрөөс хойш 90 хоногийн дотор Олборлолтын үйл ажиллагааг эхэлнэ.

5.5 ОЛБОРЛОЛТЫН ХУГАЦАА

Үр ашигтай нээлт бүрийн Олборлолтын хугацаа нь эрх бүхий байгууллагын газрын тос олборлохыг зөвшөөрсөн тухай шийдвэр гарсан өдрөөс хойш хорь (20) хуртэл жил байж болно.

5.6. ҮНЭЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР, ҮНЭЛГЭЭНИЙ ТАЛБАЙ, ОЛБОРЛОЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОН ОЛБОРЛОЛТЫН ТАЛБАЙД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ

Засгийн газрын төлөөлөгчөөс зөвшеөрөл (энэхүү гэрээний 5.4 дүгээр зүйлийн б-д заасан үйл явцын дагуу олгогдсон зөвшеөрөл) авсны үндсэн дээр Гэрээлэгч нь нэмэлт мэдээлэл буюу судалгааг үндэслэн үнэлгээний хөтөлбөр, олборлолтын төлөвлөгөө болон талбайг оөрчилж болно. Гэхдээ 7 дугаар зүйлийн дагуу нэгэнт буцааж өгсөн гэрээт талбайн аль ч хэсгийг үнэлгээний болон олборлолтын талбайд оруулж болохгүй.

5.7. ОЛБОРЛОЛТЫН ХУГАЦААГ СУНГАХ

Засгийн газрын төлөөлөгч Гэрээлэгчтэй харилцан тохиролцсоны үндсэн дээр орд ашиглах хугацааг хоёр удаа тус бүр таван (5) жилээс илүүгүй хугацаагаар сунгаж болно. Гэрээлэгч нь олборлолтын хугацаа дуусахаас жараас (60) доошгүй хоногийн өмнө олборлолтын хугацааг сунгах саналаа Засгийн газрын төлөөлөгчид бичгээр өгнө.

ЗУРГААДУГААР ЗҮЙЛ ХАЙГУУЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА

6.1. ЗААВАЛ ГҮЙЦЭТГЭХ АЖИЛ ҮҮРЭГ

- а) Гэрээлэгч нь гэрээ хучин төгөлдөр болсон өдрөөс хойш (120) хоногийн дотор Гэрээний Хавсралт В-д заагдсан хайгуулын үйл ажиллагаа явуулж эхэлнэ. Гэрээлэгч Хавсралт В-д заасан заавал зарцуулах мөнгийг хайгуулын ажилдаа зарцуулаагүй бол гүйцэтгээгүй ажилд ногдох зарцуулагдаагүй хөрөнгийг тухайн гэрээт жил дууссанаас хойш гуч (30) хоногийн дотор АМГТХЭГ-т төлнэ.
- б) Тухайн жилд Гэрээлэгч заавал гүйцэтгэх ажил үүргээс илүү ажил, үүрэг гүйцэтгэж, төлөвлөснөөс илүү зардал гаргасан тохиолдолд дараа жилийн гүйцэтгэх ажил, зардалд шилжүүлэн тооцож болно.

6.2. ӨРӨМДӨХ АРГУУД

Гэрээлэгч нь 6.1-д заасан ажил үүрэг, хайгуулын цооног өрөмдөх ажиллагааг олон улсын газрын тосны салбарт хэвшийн нийтлэг аргачлалын дагуу гүйцэтгэнэ. Дараахаа тохиолдолд хайгуулын цооногийн өрөмдлөгийг дууссанд тооцно. Үүнд:

а) өрөмдөх гүнд болон эсхүл зорилтот давхаргад хүрсэн,

б) нээлтийн цооног болсон,

- в) өрөм нь суурь чулуулагт хүрсэн,
- г) орөм нь үл нэвтрэх бинет, геологийн хэт халуун градиентэд хүрсэн.

ХАЙГУУЛЫН АЖЛЫН ХӨТӨЛБӨР БА ТӨСӨВ

Гэрээ хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш жар (60) хоногийн дотор, цаашид дараагийн гэрээт жил бүр эхлэхээс дечин таваас (45) доошгүй хоногийн өмнө Гэрээлэгч нь тухайн гэрээт жилд гүйцэтгэх хайгуулын ажлын нарийвчилсан хөтөлбөр ба төсвийг боловсруулж, Засгийн газрын төлөөлөгчид батлуулахаар өгнө. Тухайн гэрээт жил эхлэхээс гuchaас (30) доошгүй хоногийн өмнө Гэрээлэгч, Засгийн газрын төлөөлөгч хамтран хайгуулын ажлын хөтөлбөр, төсвийг хянан хэлэлцэж, Засгийн газрын төлөөлөгч батална. Гэрээлэгч нь энэхүү ажлын хөтөлбөр, төсвийг өөрчлөх зайлшгүй шаардлага гарсан тохиолдолд өөрийн саналыг Засгийн газрын төлөөлөгчид нэн даруй гаргаж өгнө. Засгийн газрын төлөөлөгч саналыг авснаас хойш ажлын арван таван (15) өдрийн дотор Гэрээлэгчтэй уулзаж, өөрчлөлтийг хянан хэлэлцэж батална. Засгийн газрын төлөөлөгч санал болгосон Ажлын хөтөлбөр, төсөвт энэхүү Гэрээ, холбогдох хууль тогтоомж болон олон улсын газрын тосны салбарт хэвшсэн нийтлэг стандарт, журамтай нийцүүлэх шаардлагын хүрээнд нэмэлт өөрчлөлт хийхийг шаардаж болно.

ДОЛДУГААР ЗҮЙЛ

ТАЛБАЙ БУЦААЖ ӨГӨХ

7.1. ГЭРЭЭ ЁСООР ТАЛБАЙ БУЦААЖ ӨГӨХ

Гэрээлэгч нь :

- а) Хайгуулын ажлын хугацааны эхний үе шат дууссанаас хойш гуч (30) хоногийн дотор гэрээт талбайн хорин таван (25) хувийг буцаан өгнө.
- б) Хайгуулын ажлын хугацааны хоёрдугаар үе шат дууссанаас хойш гуч (30) хоногийн дотор анхны гэрээт талбайн хорин (20) хувийг буцаан өгнө.
- в) Хайгуулын нийт хугацаа дуусахад үнэлгээний болон олборлолтын талбайнаас бусад бүх талбайг буцааж өгнө.
- г) Талбайг буцааж өгөхийн өмнө холбогдох хууль, тогтоомжийн дагуу бүх машин, тоног төхөөрөмжүүдийг талбайгаас зайлцуулж, талбайг хог хаягдаас цэвэрлэн, хөрс, усны бохирдлыг арилгаж, талбайн гадаргуугийн унаган төрхийг сэргээсэн байна.

7.2. ӨӨРИЙН ХҮСЭЛТЭЭР ТАЛБАЙ БУЦААЖ ӨГӨХ

- а) Гэрээлэгч талбайг бүхэлд нь эсвэл тодорхой хэсгийг өөрийн хүсэлтээр буцааж өгч болно. Ийнхүү сайн дураараа буцааж өгсөн хэсгүүдийг 7.1-д дурьдсан гэрээ ёсоор буцааж өгсөн талбайд оруулан тооцно.
- б) Гэрээлэгч 7.2 зүйлийн а-д заасны дагуу талбай буцаан өгөх нь Гэрээлэгчийн уг талбайд заавал зарцуулах мөнгөн хөренгийн хэмжээнд нөлөөлөхгүй.

7.3. ҮНЭЛГЭЭНИЙ ТАЛБАЙ

Гэрээлэгч үнэлгээний хотолборийг хэрэгжүүлсэн болоки үр ашигтай нээлт

тогоогдоогүй тохиолдолд уг үнэлгээний талбайг буцааж өгнө. Үнэлгээний хөтөлбөрийн дагуу заавал гүйцэтгэх ажил үүргээ гүйцэтгээгүй байгаа үнэлгээний талбайг сайн дураараа буцааж өгөх тохиолдолд биелүүлээгүй ажил гүйцэтгэхэд ногдох мөнгийг тухайн үнэлгээний талбайг буцааж өгөхөөс гuchaас (30) доошгүй хоногийн өмнө Засгийн газрын төлөөлөгчид төлнө.

НАЙМДУГААР ЗҮЙЛ

БҮТЭЭГДЭХҮҮН ХУВААЛТ

8.1. РОЯЛТИ

1. Гэрээлэгч хуанлийн улирал бүрт Гэрээт тосноос тооцож Роялти төлнө. Роялти нь нийт олборлосон түүхий тосны хувьтай тэнцүү байна.
2. Роялтид төлөх төлбөрийг 8.5 дугаар зүйлд заасны дагуу тооцож, улирлын сүүлийн сарын эцсийн хоногоос өмнө төлнө. Засгийн газрын төлөөлөгч энэ талаар өөр журам тогтоож болно.

8.2. ТҮҮХИЙ ТОС БОРЛУУЛАХ

- a) Гэрээлэгч олборлон хуримтлуулсан бүх түүхий тосыг борлуулна.
- b) Монгол Улсын Засгийн газар нь олборлож, хуримтлуулсан тосноос өөрт ногдох тосыг тосоор авах тохиолдолд хуанлийн улирал эхлэхээс гуч (30)-аас доошгүй хоногийн өмнө Гэрээлэгчид хэдий хэмжээгээр авах тухайгаа бичгээр мэдэгдэнэ.

8.3. ОРТӨГТ ТОС

- a) Гэрээлэгч энэхүү 8.3 дугаар зүйлд заасны дагуу газрын тостой холбогдсон үйл ажиллагааны явцад зарцуулсан өртөг, зардлаа нөхөж авах зорилгоор хуанлийн сар тутам гэрээт түүхий тосноос тодорхой хэмжээг авч ашиглах эрхтэй (үүнийг өртөгт тос гэнэ). Гэрээлэгчийн авч ашиглах эрхтэй нийт өртөгт тосны хэмжээ нь Гэрээ хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш Гэрээлэгчийн газрын тостой холбогдсон үйл ажиллагааны зардлуудын нийлбэртэй тэнцэх газрын тосны хэмжээтэй тэнцүү байна. Гэхдээ аливаа хуанлийн сард Гэрээлэгчийн авч ашиглах өртөгт тос нь тухайн сарын хугацаанд олборлож, хуримтлуулсан Гэрээт нийт түүхий тосны тэнцүү байна. Гэрээлэгч нь үйл ажиллагааны нийт зардлаа нөхөж дуустал үлдэгдэл нь дараагийн хуанлийн саруудад шилжигдэн тооцогдоно.
- b) Гэрээлэгч нь газрын тостой холбогдох зардлыг давхардуулалгүйгээр хайгуулын зардал, үйл ажиллагааны зардал болон олборлолтын зардал гэж ангилна.

Эдгээр газрын тостой холбогдох зардал нь дараах дарааллаар нехегдене.

- 1/ хайгуулын зардал;
- 2/ үйл ажиллагааны зардал;
- 3/ олборлолтын зардал ;

Тодруулга хийх үүдицс, олборлолтын зардал нь хайгуулын хугацаанд, хайгуулын зардал нь олборлолтын хугацаанд гарч болно гэдгийг зовшоөрөв.

- в) Дээр дурьдсаныг үл харгалзан, 8.1 дүгээр зүйлийн дагуу төлөгдхөн роялти болон 10 дугаар зүйлийн дагуу төлөгдхөн урамшууллууд болон бусад төлбөрүүд ихэнх төлөгдөхгүй бөгөөд энэхүү 8.3 дугаар зүйлд заасан Өртөгт тосонд орохгүй.

8.4 ХУВААХ ТОС

- а) Хуанлийн сар бүрийн гэрээт түүхий тосноос роялти болон өртөгт тосыг хасаад үлдэх хэмжээ (Хуваах тос)-г Монгол Улсын Засгийн газар болон Гэрээлэгчийн хооронд доорх хувиар хуваарилна. Үүнд:

1. Хэрвээ тухайн хуанлийн сард олборлосон гэрээт түүхий тосны өдрийн дундаж гарц нь 5000 баррель хүртэл:

Монгол Улсын Засгийн газарт
Гэрээлэгчид

2. Хэрвээ тухайн хуанлийн сард олборлосон гэрээт түүхий тосны өдрийн дундаж гарц нь 5000 баррелиас их буюу 10000 баррель хүртэл:

Монгол Улсын Засгийн газарт
Гэрээлэгчид

3. Хэрвээ тухайн хуанлийн сард олборлосон гэрээт түүхий тосны өдрийн дундаж гарц нь 10000 баррелиас их буюу 15000 баррель хүртэл:

Монгол Улсын Засгийн газарт
Гэрээлэгчид

4. Хэрвээ тухайн хуанлийн сард олборлосон гэрээт түүхий тосны өдрийн дундаж гарц нь 15000 баррелиас их буюу 20000 баррель хүртэл:

Монгол Улсын Засгийн газарт
Гэрээлэгчид

5. Хэрвээ тухайн хуанлийн сард олборлосон гэрээт түүхий тосны өдрийн дундаж гарц нь 20000 баррелиас их байвал:

Монгол Улсын Засгийн газарт
Гэрээлэгчид

- б) Гэрээт түүхий тосны өдрийн дундаж хэмжээг тогтоохдоо тухайн сард олборлосон түүхий тосны нийт хэмжээг тухайн сарын өдрийн тоонд хуваана.

- г) Хуваах тосны Монгол Улсын Засгийн газарт ногдох тосны үнэлгээг Гэрээний 8.5 дугаар зүйлд заасны дагуу хийх бөгөөд Монголын Засгийн газарт ногдох тосны төлбөрийг хуваасан өдрөөс хойш 30 хоногийн дотор Засгийн газрын төлөөлөгчид төлөх бөгөөд эсхүл Монгол Улсын Засгийн газраас зөвшөөрсөн тохиолдолд өөр хэлбэрээр гүйцэтгэж болно.

8.5 ГЭРЭЭТ ТОСНЫ ҮНЭЛГЭЭ

Хуанлийн сар бүр роялти, өртөгт тос болон хуваах тосны үнэлгээг хийх зорилгоор ашиглаж буй Гэрээт түүхий тосны үнийн дүнг Гэрээлэгчийн тухайн сарын гэрээт түүхий тосны борлуулалттай уялдуулан жигнэсэн дундаж армз-ленгс үнийг ашиглан тооцоходоо Гэрээт талбайгаас армз-ленгс үнийг тодорхойлсон цэг хүртэлх бүх тээврийн зардлыг хасах бөгөөд газрын тосны салбарт хэвшсэн буюу зонхилж буй зардлаас хэтрэхгүй байна. Хэрэв Гэрээлэгч тухайн сард армз-ленгс худалдааг ашиглаагүй бол Гэрээт түүхий тосны үнийг тээврийн зардалд тохируулан тухайн бүс нутагт хоёр талын харилцан хүлээн зөвшөөрч

боловхийц армз-ленгс худалдааны зарчмаар тооцно.

8.6 БОРЛУУЛАЛТЫН УРДЧИЛСАН ТООЦОО

- a) Үр ашигтай нээлт бүрийн хувьд Гэрээлэгч нь хуанлийн улирал эхлэхээс гучас (30) доошгүй хоногийн дотор олон улсын газрын тосны салбарт хэвшсэн нийтлэг аргачлалын дагуу Гэрээлэгчийн олборлож борлуулахаар тооцолж буй түүхий тосны дээд хэмжээ, зах зээлийн үнэ болон холбогдох бусад хүчин зүйлүүдийн тухай урдчилсан мэдээг Засгийн газрын төлөөлөгчид хүргүүлнэ.
- б) Гэрээлэгч тэрхүү мэдээнд тухайн Хуанлийн улиралд төлөгдөх Роялти, өртөгт тосны үнэ болон Монгол Улсын Засгийн газар, Гэрээлэгчид ногдох Гэрээт түүхий тосны тооцоог багтаасан байна. Гэрээлэгч урдчилан төлевлесэн хэмжээний газрын тосыг олборлохыг эрмэлзэнэ. Гэрээлэгч Үр ашигтай нээлт бүхий хэд хэдэн орд цооногоос олборлох хэмжээг нэгтгэн тооцож болно.

8.7 ДУТАЛТ БА ХЭТРҮҮЛЭЛТ

Аль нэг тал нь хуваарьт түүхий тосоо зарим үед бүрэн хэмжээгээр нь авах боломжгүй байж болохыг хүлээн зөвшөөрч байна. (энэ тохиолдолд уг талыг дутуу авагч гэнэ). Ийм тохиолдолд негеө тал нь ашиглалтыг бүрэн хэмжээгээр үргэлжлүүлэн орлогыг өөрийн талдаа хуваарилж (энэ талыг хэтрүүлэн авагч гэнэ) болно. Гэрээлэгч хуваарилалтын зөв тэнцвэрийг тогтоохын тулд дутуу авагчийн нөхөн авах түүхий тосны хэмжээг тооцон бүртгэнэ. Хуваарилалтын зөв тэнцвэрийг тогтоохын тулд дутуу авагч талд ногдох түүхий тосыг нөхөж өгнө. Гэхдээ энэ хуваарилалтыг үйлдвэрлэл, борлуулалтын хэвийн үйл ажиллагаанд саад учруулахгүй байх нехшлөөр хийж гүйцэтгэнэ.

ЕСДҮГЭЭР ЗҮЙЛ

ХИЙН БҮТЭЭГДЭХҮҮН ХУВААЛТ

9.1 ХИЙН ЗАХ ЗЭЭЛ

Хэрэв үр ашигтай болох нь тогтоогдсон аливаа нээлтээс байгалийн хий олборлох бололцоотой бол ут хийг олборлож, борлуулах хөтөлбөрийг хэрэгжүүлэх нь эдийн засгийн хувьд үр ашигтай гэж үзэх нэг буюу хэд хэдэн зах зээл Монгол Улсад болон хилийн чандад байгаа эсэхийг тогтоох /Тогтоогдсон зах зээлийг цаашид “Арилжааны хийн зах зээл” гэнэ) зорилгоор аль нэг талын хүсэлтээр Засгийн газрын төлөөлөгч, Гэрээлэгч нар уулзана. Хэрэв Засгийн газрын төлөөлөгч болон Гэрээлэгч нь арилжааны хийн нэг буюу хэд хэдэн зах зээл байгааг тогтоовол Талууд энэ талаар харилцан хүлээн хүлээн авч болохуйц борлуулалтын тохиролцоо хийхийг эрмэлзэнэ. Хэрэв Засгийн газрын төлөөлөгч болон Гэрээлэгч нь арилжааны хийн нэг буюу хэд хэдэн зах зээл байгааг тогтоогоогүй эсвэл 9.2 дугаар зүйлд заасанчлан харилцан хүлээн авч болохуйц борлуулалтын тохиролцоо байгуулаагүй тохиолдолд өөрөөр тохиролцоогүй бол энэ асуудлаар улиралд нэгээс цөөнгүй удаа уулзана. Хэрэв Гэрээлэгч арилжааны хийн нэг буюу хэд хэдэн зах зээл байгааг тогтоосон боловч Засгийн газрын төлөөлөгч үүнийг хүлээн зөвшөөрөхгүй бол Гэрээлэгч Бүтээгдэхүүн хуваах гэрээний 9.2 дугаар зүйлд заасны дагуу холбогдох байгалийн хийн нээлтийг ямар ч тохиолдолд олборлох эрхтэй. Энэхүү Гэрээнд заасан аливаа зүйлээс үл хамааран талууд арилжааны хийн нэг буюу хэд хэдэн зах зээл байгаа эсэхийг тогтоох, харилцан хүлээн хүлээн авч болохуйц борлуулалтын тохиролцоо байгуулах талаар

үргэлжлүүлэн ажиллах хугацаанд Гэрээлэгч байгалийн хийн нээлт бүхий талбайг нээлт хийгдсэн өдрөөс эхлэн 7 жилийн турш хадгалан үлдэх эрхтэй.

9.2 БАЙГАЛИЙН ХИЙН ӨРТӨГ НӨХӨЛТ БА БҮТЭЭГДЭХҮҮН ХУВААЛТ

Хэрэв үр ашигтай болох нь тогтоогдсон аливаа нээлтээс нээлтийн цоног эсвэл байгалийн хий олборлох бололцоотой бол холбогдох хууль тогтоомжийн хүрээнд энэхүү гэрээний 9.1 дүгээр зүйлд заасан хадгалах эрх, үүргийг хүчин төгөлдөр болгох шаардлагатай гэж үзвэл эсвэл Гэрээлэгчийн хүсэлтийн дагуу АМГТХЭГ нь байгалийн хийн нээлттэй холбогдуулан Гэрээлэгчтэй шинэ Бүтээгдэхүүн хуваах гэрээ байгуулна. Шинэ Бүтээгдэхүүн хуваах гэрээний заалтууд нь энэхүү Бүтээгдэхүүн хуваах гэрээний заалтуудтай адил байна. Харин уг гэрээнд дараах өөрчлөлтүүдийг заавал тусгана. Үүнд:

- Энэхүү Бүтээгдэхүүн хуваах гэрээ байгалийн хийтэй холбогдолтой тул “түүхий тос” хэмээх үгийг “байгалийн хий” гэж зайлшгүй өөрчлөх,
- Нээлт нэгэнт үр ашигтай нээлт байх тул хайгуулын ажлыг цаашид хийх шаардлагагүй,
- энэхүү Гэрээний 8.4 дүгээр зүйлд заасан АМГТХЭГ-т ногдох түүхий тосны хэмжээ өдрийн олборлолтоос хамааран нэмэгдэх шатлалтай бүтээгдэхүүн хуваалтыг 1 баррель түүхий тос зургаан мянган /6000/ стандарт куб фийт байгалийн хийтэй тэнцэж байхаар шилжүүлж тооцно.

Хэрэв Талууд Бүтээгдэхүүн хуваах гэрээний нөхцлүүд дээр 6 сарын дотор хэлэлцэн, тохиролцож чадахгүй бол 22 дугаар зүйлд заасны дагуу Арбитрийн шүүхэд хандан асуудлыг эцэслэн шийдвэрлүүлнэ.

9.3. ДАГАЛДАХ ХИЙГ АШИГЛАХ

Энэхүү Гэрээнд заасан аливаа зүйлээс үл хамааран Гэрээлэгч:

- Дагалдах байгалийн хийг эрчим хүчний үүсгүүр, дахин үйлдвэрлэл болон даралтыг хэвийн хадгалах гэх мэт газрын тостой холбогдсон үйл ажиллагаанд үнэ төлбөргүй ашиглана.
- Холбогдох хууль, тогтоомжоор хориглосноос бусад дагалдах байгалийн хийг шатаана.
- Дагалдах байгалийн хийг нөөцийн саванд буцаан шахна.

АРАВДУГААР ЗҮЙЛ

УРАМШУУЛАЛ, ТАТВАР БА БУСАД ТӨЛБӨРҮҮД

10.1 ГАРЫН УСГИЙН УРАМШУУЛАЛ, ОЛБОРЛОЛТ ЭХЭЛСНИЙ УРАМШУУЛАЛ БОЛОН ОЛБОРЛОЛТЫН УРАМШУУЛАЛ

- Гэрээ Монгол Улсын Засгийн газраар батламжлагдсан өдрөөс жар /60/ хоногийн дотор Гэрээлэгч Засгийн газрын төлөөлөгчид Гэрээнд гарын үсэг зурсны урамшуулал .доллар төлино.
- Гэрээлэгч нь олборлолт эхэлсний урамшууллыг анхны Үр ашигтай нээлтийн өдрөөс хойш гуч (30) хоногийн дотор .ам.доллар толио.

- в) Гэрээлэгч Монгол Улсын Засгийн газарт олборлолтын урамшууллыг дараахь байдлаар төлнө:
1. Өдөрт дундажаар 5000 баррелиас илүү Гэрээт түүхий тосыг нэг хуанлийн сар олборлосны дараа ам. доллар;
 2. Өдөрт дундажаар 10000 баррелиас илүү Гэрээт түүхий тосыг нэг хуанлийн сар олборлосны дараа ам. доллар;
 3. Өдөрт дундажаар 20000 баррелиас илүү Гэрээт түүхий тосыг нэг хуанлийн сар олборлосны дараа ам. доллар;
 4. Өдөрт дундажаар 30000 баррелиас илүү Гэрээт түүхий тосыг нэг хуанлийн сар олборлосны дараа ам. доллар;

10.2 СУРГАЛТЫН УРАМШУУЛАЛ

Гэрээлэгч гэрээ хүчин төгөлдөр болсноос хойш жил бүр Гэрээт жилийн эхнээс гуч (30) хоногийн дотор сургалтын урамшуулал Засгийн газрын төлөөлөгчид төлнө.

10.3 TATVAR

Гэрээлэгч энхүү гэрээний 16 дугаар зүйлд зааснаас бусад татварыг Монгол Улсын хууль, тогтоомжийн дагуу төлнө.

10.4 ТАЛБАЙН ДЭНЧИН

- а) Гэрээлэгч Монгол Улсын Газрын тосны тухай хуулийг хэрэгжүүлэх журмын дагуу Гэрээт талбайн хэмжээгээр дэнчингийн төлбөрийг жил бүр дараахь байдлаар АМГТХЭГ-т төлнө.
- i. Хайгуулын үеийн эхний үе шатанд
Гэрээт талбайн нэг хавтгай дөрвөлжин км бүрт
(Олборлолтын талбайг оруулахгүй)
 - ii. Хайгуулын үеийн хоёр дахь үе шатанд
Гэрээт талбайн нэг хавтгай дөрвөлжин км бүрт
(Олборлолтын талбайг оруулахгүй)
 - iii. Хайгуулын үеийн гурав дахь үе шат болон сунгалтын хугацаанд Гэрээт талбайн нэг хавтгай дөрвөлжин км бүрт (Олборлолтын талбайг оруулахгүй)
 - iv. Ашиглалтын талбайн нэг хавтгай дөрвөлжин км бүрт

- б) Гэрээлэгч нь талбайн дэнчинг Гэрээ хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш ерэн /90/ хоногийн дотор, дараагийн гэрээт жилүүдийн талбайн дэнчинг дараагийн гэрээт жилийн хүчин төгөлдөр гэж тооцогдох өдрөөс хойш гуч (30) хоногийн дотор тус төлнө.

10.5 ЗАХИРГААНЫ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ШИМТГЭЛ

Гэрээлэгч нь АМГТХЭГ-т газрын тосны тухай хууль, холбогдох хууль, тогтоомжийн дагуу дараах захиргааны үйлчилгээний шимтгэл төлнө. Үүнд:

- а) Гэрээт талбай авах захиалга
- б) Хайгуулын хугацааг сунгах
- в) Олборлолтын талбай авах захиалга
- г) Олборлолтын талбайн хэмжээг өөрчлөхөд
- д) Олборлолтын хугацааг сунгах
- е) Газрын тостой холбогдсон үйл ажиллагааны аливаа эрх, үүргийг шилжүүлэх

АРВАН НЭГДҮГЭЭР ЗҮЙЛ

ХЭМЖИЛТ

11.1 БҮТЭЭГДЭХҮҮН ХУВААХ ХЭМЖИЛТ

а) Гэрээнд оролцогч талуудын хооронд хуваах Гэрээт түүхий тос, түүний дагалдах хийн хэмжээг тодорхойлох зорилгоор хэмжилтийг (Бүтээгдэхүүн хуваах хэмжилт) олон улсын газрын тосны үйлдвэрлэлд хэвшсэн нийтлэг аргачлал, зарчмыг үндэслэн гүйцэтгэнэ. Гэхдээ дээрхээс бусад (үүнд ганцаарчилсан цооногийн олборлолтын хэмжээг тогтоох ба үнэлэх хэмжилт орно) зорилгоор өөр төрлийн хэмжилт хийгдэж болох бөгөөд энэ нь Бүтээгдэхүүн хуваах хэмжилтийн шаардлагад заавал нийцэх ёсгүй гэдгийг харилцан тохиролцов.

б) Бүтээгдэхүүн хуваах хэмжилтийг Хэмжилтийн цэг дээр хийнэ. Хэрэв гэрээт түүхий тос нь аливаа учир шалтгааны улмаас нэгээс дээш тооны олборлолтын талбайд хамрагдаж байвал Гэрээлэгч нь тухайн бүтээгдэхүүнийг олон улсын газрын тосны салбарт хэвшсэн нийтлэг аргачлалаар хуваарилна.

в) Талууд энэхүү 11 дүгээр зүйлд заасны дагуу бүтээгдэхүүн хуваах хэмжилт хийгдэхээс өмнө өөрт ногдох түүхий тосыг ашиглах эрхгүй болохыг харилцан хүлээн зөвшөөрөв. Гэхдээ Монгол Улсын дотоод хэрэгцээг хангах зорилгоор Монгол Улсын Засгийн газарт ногдох түүхий тосыг ашиглах эрхийг үүгээр хязгаарлахгүй болно.

11.2 ХЭМЖИЛТИЙГ ЗАЛРУУЛАХ

а) Хэрэв Гэрээлэгч нь Бүтээгдэхүүн хуваах хэмжилтийн аль нэг багаж хэрэгсэлд тохируулга хийх, засварлах эсвэл солихыг хүсвэл Засгийн газрын төлөөлөгчид мэдэгдэж, хянуулна.

б) Засгийн газрын төлөөлөгч нь бүтээгдэхүүн хуваах аливаа хэмжилтийг ямар ч үед ажиглах, үнэн зөвийг тодорхойлох зорилгоор шалгалт хийх эрхтэй. Хэрэв шалгалтаар хэмжилт нь олон улсын газрын тосны салбарт хэвшсэн нийтлэг аргачлал болон стандартад нийцэхгүй болох нь илэрвэл Засгийн газрын төлөөлөгч түүнийг залруулах арга хэмжээ авахыг Гэрээлэгчээс шаардана. Хэрэв Гэрээлэгч нь энэ шаардлагыг хүлээн авсан өдрөөс хойш 30 хоногийн дотор залруулах арга хэмжээ авч эхлээгүй, эхэлсэн ч явц нь удаашралтай байвал Засгийн газрын төлөөлөгч засварыг хийж зардлыг Гэрээлэгчээр төлүүлнэ.

в) Хэмжилт алдаатай байх нь тогтоогдвол Гэрээлэгч хэмжилтийн алдаатай байх үеийн олборлолтын үнэн бодит хэмжээг тогтоож, өмнөх хэмжилтийг залруулах бүхий л арга хэмжээ авна. Гэрээлэгч нь гүйцэтгэсэн залруулгын ажлын тухай тайланг АМГТХЭГ-т хургуулж, батлуулна. Хэрвээ хэмжилтийн алдаа анх гарсан хугацааг тогтоох боломжгүй бол урьд хийгдсэн шалгалтын өдөр ба алдааг илрүүлсэн өдрийн хоорондох хугацааны дундах үеийг алдаатай хэмжилт эхэлсэн цагаар тооцно.

11.3 ХЭМЖИЛТИЙН БҮРТГЭЛ

Гэрээлэгч бүтээгдэхүүн хуваах хэмжилтийн бүртгэлийн баримтуудыг тав (5) болон түүнээс дээш жилийн хугацаанд хадгалах бөгөөд Засгийн газрын төлөөлөгч нь эдгээр бүртгэлтэй шаардлагатай үедээ танилцах эрхтэй.

АРВАНХОЁРДУГААР ЗҮЙЛ ТЕХНИКИЙН МЭДЭЭЛЭЛ

12.1 ТЕХНИКИЙН МЭДЭЭЛЛИЙГ ӨМЧЛӨХ

Засгийн газрын төлөөлөгч нь газрын тосны үйл ажиллагааны үр дүнд гэрээлэгчийн цуглуулсан геологи, геофизик, петрофизик, геохими, цооногийн бүх хаалтын тайлан, өрөмдлөгийн мэдээлэл, петрологийн мэдээлэл, гүйцэтгэлийн тайлан болон бусад бүх эх мэдээлэл, эдгээрийг боловсруулж тайлан хийж дүгнэсэн үр дүнгийн тайлан, зураг зэрэг мэдээллийн бүх эх хувийг Гэрээлэгчид энэхүү гэрээний дагуу газрын тостой холбогдсон үйл ажиллагаа явуулах зорилгоор эдгээр мэдээллийг үнэ төлбөргүйгээр ашиглах эрхийг олгох нөхцөлтэйгээр өмчилнэ. Гэрээлэгчийн газрын тостой холбогдсон үйл ажиллагаанд туслалцаа үзүүлэх үүднээс АМГТХЭГ өөрийн өмчлөлд буй эсвэл гэрээт талбайд холбогдо бүх мэдээллийг энэхүү гэрээг хийж гүйцэтгэнээс хойш гуч (30) хоногийн дотор үнэ төлбөргүйгээр Гэрээлэгчид өгнө.

12.2 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЕРӨНХИЙ БҮРТГЭЛ

Гэрээлэгч газрын тосны хайгуул, олборлолт, борлуулалт, ашиглалт, боловсруулах болон бусад үйл ажиллагааны тухай бүртгэлийг олон улсын газрын тосны аж үйлдвэрт хэвшсэн нийтлэг загвар болон Хавсралт “Г”-д заасны дагуу хөтөлнө. Эдгээр бүртгэлийг англи хэл дээр хөтөлнө. Гэрээлэгч нь энэхүү бүртгэл, тайлангийн хувийг сар, улирал, жил бүрээр Засгийн газрын төлөөлөгчид гаргаж өгнө.

12.3 ХЛЙГУУЛ, ПЕТРОФИЗИК ЛАБОРАТОРИЙН СУДАЛГАА, ОЛБОРЛОЛТ БОЛОН ОЛБОРЛОЛТЫН ТУХАЙ МЭДЭЭЛЭЛ

Гэрээлэгч энэхүү мэдээллийг олон улсын газрын тосны үйлдвэрлэлд хэвшсэн нийтлэг аргачлал, зарчмыг үндэслэн боловсруулж, үр дүнгийн тайлан материалыг Засгийн газрын төлөөлөгчид хүргүүлнэ. Гэрээлэгч холбогдох мэдээллийг боловсруулсаны дараа хуулбарыг боломжит түргэн хугацаанд АМГТХЭГ-т хүргүүлэх бөгөөд харин эх хувийг Гэрээт талбайн холбогдох хэсгийг буцаан өгсний дараа АМГТХЭГ-т өгнө. / Гэрээлэгч талбайн буцаан өгөөгүй хэсэгт хайгуул болон үнэлгээ хийх зорилгоор буцаан өгсөн хэсэгт холбогдох мэдээллийн хуулбарыг гэрээний хугацаанд хадгалж болно./

Гэрээлэгч нь лабораторийн туршилт, шинжилгээ хийх зорилгоор чөмөг чулуу, шlam, чулуулаг болон газрын тосны сорьц дээжийг Монгол Улсын хилээр авч гаргаж болох бөгөөд хилээр гаргаж буйтай адил чанар, хэмжээтэй сорьц дээжийг эхлээд АМГТХЭГ-т хүргүүлнэ. Засгийн газрын төлөөлөгч эдгээр дээжийг буцааж авах хүснэгтээ түүнийг гаргаснаас хойш 1 жилийн дотор ирүүлэхгүй бол Гэрээлэгч нь уг дээжийг өөрийн үзэмжээр ашиглана. Хэрэв Гэрээлэгч нь цооногт туршилт хийхээр бол Засгийн газрын төлөөлөгчид туршилтын ажлын хугацааг мэдэгдэх бөгөөд АМГТХЭГ-ын эрх олгосон төлөөлөгч тэрхүү туршилтын явцад байлцахыг зөвшөөрнө. / АМГТХЭГ-ын эрх олгосон төлөөлөгчийн цооногт туршилт хийхэд оролцох үүргээ биелүүлгээгүйн улмаас туршилтын ажлыг зогсоогүй./

12.4 ОЛБОРЛОЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Гэрээлэгч нь олборлолтын үйл ажиллагаа явуулж буй цооног бурзэс олборлосон тос, хийн хэмжээ болон цооногийн монтажийн өөрчлөлтийг үзүүлсэн бүртгэлийг хетлөх ба холбогдох мэдээлэл, тайланг холбогдох хууль, тогтоомж болон Хавсралт "Г"-д заасны дагуу Засгийн газрын төлөөлөгчид хүргүүлнэ.

12.5 ХАМТАРСАН ХОРОО

Энэ гэрээний Үр ашигтай нээлтийн дагуу Олборлолтын хугацаа эхэлмэгц Гэрээлэгч болон Засгийн газрын төлөөлөгч Гэрээт талбай дахь олборлолт явуулж байгаа бүх агууламжийн ашиглалтын үйл ажиллагаа, мэдээллийг судлах, түүнчлэн талуудын хоорондох удирдлагын холбогдолтой асуудлыг зохицуулах зорилгоор хамтарсан хороо байгуулна.

12.6 БУСАД АШИГТ МАЛТМАЛ

Гэрээлэгч газрын тостой холбогдсон үйл ажиллагааныхаа явцад эдийн засгийн үр ашигтай бусад ашигт малтмалын нөөц илрүүлбэл энэ тухай Засгийн газрын төлөөлөгчид даруй мэдэгдэнэ. Эдгээр ашигт малтмал Монгол Улсын өмч байна.

12.7 НУУЦЛАЛ

Талууд энэхүү гэрээ болон энэхүү гэрээний дагуу хийгдсэн ажлын талаарх бүх мэдээллийг / Гэрээний 12 дугаар зүйлд дурдсан бүх тайлан мэдээг оролцуулан/ нууцалж, нөгөө талын зөвшөөрөлгүй гуравдагч этгээдэд дамжуулж үл болно. Дээр өгүүлсэн нууцлалын талаар хүлээх үүрэг нь дараах зүйлд хамаарахгүй. Үүнд :

ЭХ СУРВАЛЖ: WWW.ILTODGEREE.MN

- 1) аль нэг тал өөрийн ажиллагсад, хувь нийлүүлэгчид, зөвлөгчид, лаборатори, зээл олгох этгээдүүд, мөн Туслан гүйцэтгэгчид газрын тостой холбогдсон үйл ажиллагаа явуулах шаардлагын хүрээнд нуушлалыг задалж болно.
- 2) аль нэг тал нь дагаж мөрдөж буй зохих хууль, тогтоомж Гэрээлэгчийн болон Гэрээлэгчийн харьяа байгууллагын үнэт цаас бүртгэгдсэн аливаа хөрөнгийн биржийн дүрэм журмын хүрээнд нууцыг задалж болно.
- 3) энэхүү гэрээ байгуулах үед хүлээн авагч мэдэж байсан мэдээлэлээ шаардлагатай тохиолдолд батлах үүргийг хүлээн авагч хүлээнэ.
- 4) хүлээн авагчийн энэхүү Гэрээний дагуу хүлээх үүргийн зөрчил болох үйлдэл буюу эс үйлдлээс үл хамааран олон нийтийн мэдээллийн санд байх буюу дараа нь орсон мэдээлэл; эсвэл
- 5) хүлээн авагчийн итгэснээр эрх нь олгогдсон гуравдагч этгээдээс хүлээн авагчид дамжуулсан мэдээлэл

АРВАНГУРАВДУГААР ЗҮЙЛ

НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛ ТООЦООНЫ МЭДЭЭЛЭЛ

13.1 НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛ

Гэрээлэгч нь газрын тосны үйл ажиллагаанд хамаарах нягтлан бодох бүртгэлийг Хавсралт Г-д заасан Бүртгэл тооцооны журам болон олон улсын газрын тосны үйлдвэрлэлд хэвшсэн нягтлан бодох бүртгэлийн нийтлэг зарчмуудын дагуу хөтөлнө. Эдгээр нягтлан бодох бүртгэлийг АНУ-ын доллараар, англи хэл дээр хөтөлнө.

13.2 БҮРТГЭЛ ТООЦООНЫ ТАЙЛАН

Гэрээлэгч нь бүртгэл тооцооны тайлан болон бусад мэдээллийг Засгийн газрын төлөөлөгчид Хавсралт В-д заасан Бүртгэл тооцооны журмын дагуу бүрдүүлэн, хүргүүлж байна. Гэрээлэгч Монголд төлөөлөгчийн газраа нээсний дараа газрын тостой холбогдсон үйл ажиллагааны бүртгэл тооцооны тайлангийн хувийг төлөөлөгчийн газартaa байлгах бөгөөд Засгийн газрын төлөөлөгч шаардлагатай үед Гэрээлэгчид мэдэгдсний үндсэн дээр түүнийг шалгаж, аудит хийнэ. Бүх баримт бичгийг тэдгээрийн бий болсон цагаас таван (5) жилийн хугацаанд хадгална.

13.3 САНХҮҮГИЙН ХЯНАЛТ

- a) Засгийн газрын төлөөлөгч нь /эсвэл түүний томилсон аудитор/ Гэрээлэгчийн газрын тостой холбогдсон үйл ажиллагааны санхүүгийн бүртгэл тооцо болон бусад холбогдох баримт бичигт шаардлагатай үед Гэрээлэгчид мэдэгдсний үндсэн дээр шалгаж, аудит хийх эрхтэй. Ийнхүү шалгалт, аудит хийхдээ Гэрээлэгчийн газрын тостой холбогдсон үйл ажиллагааг тасалдуулахгүй.
- б) Санхүүгийн хяналттай холбогдон гарах зардлыг Гэрээлэгч хариуцина. Хэрэв тухайн хуанлийн жилд /12 сард/ нэгээс дээш удаа шалгалт хийх бол илүү хийгдэх шалгалтын зардлыг АМГТХЭГ хариуцина.

13.4 ДУДИТ

- a) Гэрээний 13.3 дугаар зүйлд заасны дагуу шалгала хийхдээ, Гэрээлэгчийн санхүүгийн данс, санхүүгийн тайлан, бараа материалын бүртгэл ба бараа материал, ваучер, цалингийн төлбөр, нэхэмжлэх, Гэрээнд шууд буюу шууд бусаар хамрагдах аливаа төрлийн гэрээ, туслан гүйцэтгэх гэрээ, газрын тосны үйл ажиллагааны талаар холбогдох бусад баримт бичиг, бичилтүүдийг шаардлагатай үед, зохих үндэслэлийн дагуу шалгах эрхтэй.
- b) Түүнчлэн, тухайн шалгалтын дагуу Гэрээлэгчийн Монголд болон бусад улсад орших газрын тосны үйл ажиллагаатай холбогдох газрууд, бүх үйлдвэрлэлийн байр, байгууламж, агуулах болон конторт очиж, түүний дотор эдгээр үйл ажиллагаатай холбогдох ажилтантай уулзаж, шаардлагатай үед, зохих үндэслэлийн дагуу шалгах эрхтэй. Гадаадад хийгдэх санхүүгийн хяналт, шалгалттай холбогдон гарах зардлыг АМГТХЭГ хариуцна.

АРВАН ДӨРӨВДҮГЭЭР ЗҮЙЛ

ЗАСГИЙН ГАЗРЫН ТУСЛАЛЦАА

14.1 ЕРӨНХИЙ ТУСЛАЛЦАА

Гэрээлэгч нь газрын тостой холбогдсон үйл ажиллагаа явуулж, энэ Гэрээний зорилгыг биелүүлэхийн тулд АМГТХЭГ-аас дэмжлэг туслалцаа хүсч болохыг талууд хүлээн зөвшөөрч байна. Монгол Улс болон Гэрээлэгчийн ашиг тусын тулд энэхүү Гэрээг хэрэгжүүлэх үүднээс газрын тостой холбогдсон үйл ажиллагаа явуулахад шаардлагдах засгийн газрын зөвшөөрөл авах, улсын бүртгэлд бүртгүүлэх, виз болон газрын тостой холбогдсон үйл ажиллагаа явуулахтай холбогдох бусад зөвшөөрөл болон эрхийг олж эзэмших зэрэг Гэрээлэгчийн эрхээ хэрэгжүүлэх, хүлээсэн үүргээ гүйцэтгэхд АМГТХЭГ нь Гэрээлэгчид туслуулахаар өөрийн нэг буюу хэд хэдэн ажилтныг томилон ажиллуулж болно. Томилогдсон ажилтантай холбогдон гарах зардлыг АМГТХЭГ болон Гэрээлэгчийн хооронд байгуулах өөр гэрээгээр харилцан тохиролцно.

14.2 БУСАД ТУСЛАЛЦАА

АМГТХЭГ өөрийн эрх хэмжээний хүрээнд Гэрээлэгчийн хүсэлтийн дагуу барилга байгууламж барих, тоног төхөөрөмж суурилуулах, ажиллах хүч бэлтгэх, тээвэрлэлт хийх, аюулгүй байдлыг хангах, газар ашиглах зөвшөөрөл авахтай холбоотой асуудлаар дэмжлэг үзүүлнэ. Эдгээр барилга байгууламж, сэлбэг хэрэгсэл, ажиллах хүч дутагдсан тохиолдолд АМГТХЭГ нь тэдгээрээр хангах арга хэмжээ авна. Гэрээлэгчийн хүсэлтийн дагуу АМГТХЭГ-аас дээрх арга хэмжээтэй холбогдон гарсан зарлудыг Гэрээлэгч АМГТХЭГ-т нөхөж төлнө. Эдгээр нөхөн төлбөрийг тухайн үеийн ханшаар АНУ-ын ам. доллараар гүйцэтгэнэ.

АРВАН ТАВДУГААР ЗҮЙЛ

ӨМЧИЙГ АШИГЛАХ, ӨМЧЛӨХ, ЭРХ БА ӨМЧ ШИЛЖҮҮЛЭХ

15.1 ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ БА БАРИЛГА БАЙГУУЛАМЖ

Гэрээлэгчийн бүрэн өмч болох, газрын тостой холбогдсон үйл ажиллагаанд ашиглагдсан, өртгийг нь нөхөхөөр нэр заагдсан тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, нөөц хангамжийн хэрэгслийн зардал өртгийг Гэрээлэгч нөхөж авмагц тэдгээр тоног төхөөрөмж, хангамжийн хэрэгслийн зардал өртгийг Гэрээлэгч нөхөж авмагц тэдгээр тоног төхөөрөмж,

багаж хөргсөл, нөөц хангамжийн хөргсөл нь номыгдаа ортох төлбөрийн эр Монгол Улсын төрийн өмч болно.

Хөгөв гэрээнд өөрөөр залгаагүй бол Гэрээлгчийн бүрэн өмчлөлд буй тоног төхөөрөмж, багаж хөргсөл, нөөц хангамжийн хөргсөл, эд хөдлийн хөрөшгө нь энхүү Гэрээ дуусгавар болоход нэмэгдэл өртөг төлбөргүйгээр Монгол Улсын төрийн өмчлөлд шилжин. Энхүү 15.1 заалт нь Гэрээлгч өөрийн салбар болон бусад эгээдээс түрээсээр авч ашигласан эд зүйлд хамаарахгүй голгийн харилсан обий нь тов.

15.2 ГЭРҮҮЛТӨСҮҮГ ЗЭСМШИН

Энхүү Гэрээний 8 ба 9 дүгээр юйчин дагуу Гэрээлгчийн хуваарыг түүхийг тос хуваах хэмжилтийн хийснэгийг дээр буюу Гэрээлгч. Засгийн газрын тогтолцоогийн харилсан тохиролцсон бусад газарт Гэрээлгчийн мэдрэл ишигжин.

АРВАНЗУРГААДУГААР ЗҮЙЛ

ТАТВАРААС ЧОЛЮӨЛӨХ ТУХАЙ

16.1 ГОРЛОДГИЧ ИМПОРТ БАА ЭКСПОРТ ХИЙХ ТУХАЙ

а) “Гаалийн тарифын тухай хууль”-ийн 21.1-т заасны дагуу дараах зүйлсийн таалийн татвараас чөлөөлнө:

- 1) энхүү гэрээний дагуу газрын тостой холбогдсон үйл ажиллагаанд шаардагдах техник, тоног төхөөрөмж, материал, түүхий эд сэлбийн хөргсөл, автобензин, дизелийн түүши;
- 2) энхүү гэрээний дагуу газрын тостой холбогдсон үйл ажиллагаанд зориулсан буцаан гаргах нөхцөлгүйн өөр гаалийн нутаг давсгяруу оруулсан техник, тоног төхөөрөмжийг буцаан гаргах;
- 3) гэрээлгчийн хуваарт газрын тосыг гаргах.

б) “Нэмэгдсэн ортгийн албан татварын хууль”-ийн 13.2.12-т заасны дагуу газрын тосны салбарт бүтээгдхүүн хуваах зарчмаар Монгол Улсын Засгийн тааралын байгуулсан гэрээний дагуу газрын тостой холбогдсон үйл ажиллагаанд зориулсан импортогдсон техник, тоног төхөөрөмж, материал, түүхий эд сэлбийн хөргсөл, автобензин, дизелийн түлшийг нэмэгдсэн өртгийн татвараас чөлөөлнө.

в) “Аж ахуйн цэгж, байгууллагын орлогын албан татварын хууль”-ийн дагуу Газрын тосны салбарт бүтээгдхүүн хуваах зарчмаар Монгол Улсын Засгийн тааралын байгуулсан гэрээний дагуу Монгол Улсад үйл ажиллагаа явуулж байгаа гадаалын аж ахуйн нэгжийн өөрт нь ногдох бүтээгдхүүний борлуулаглаас одсон ораогод болон түүнийг гадаадад гүйвуулах үед ногдуулах татвараас тус тус чөлөөлнө.

16.2 Гэрээлгчийн Туслан гүйштгэгчид, тэдгэрийн салбар байгуулсан ажиллагаад нь энхүү гэрээний 16 дугаар зүйл заасан эрхийг нэгж ашиг үзүүн.

АРВАНДОЛДУГААР ЗҮЙЛ

ВАЛЮТ СОЛИЛЦООНЫ ЭРХ

17.1 ГАДААД ВАЛЮТ

Гадаад валютыг худалдан авах буюу худалдахад Монгол Банкнаас тогтоосон тухайн өдрийн албан ханшаар тооцно. Валютын ханшны зөрүүгээс үүссэн ашиг, алдагдал нь Гэрээлэгчийн дансанд тооцогдож, бичилт хийгдэнэ.

17.2 ГАДААДЫН БАНКИН ДАХЬ ДАНС

Гэрээлэгч хилийн чанадад гадаадын банкуудад аливаа валютын данс нээх, гүйлгээ хийх мөн эдгээр дансыг бүрэн хяналтандaa байлгах, ийм дансанд байгаа мөнгөн хөрөнгийг чөлөөтэй ашиглах, хадгалах бүрэн эрхтэй болно.

17.3 ВАЛЮТ СОЛИХ ЭРХ

Гэрээлэгч нь валют солих дараах эрхийг эдэлнэ. Үүнд:

- a) Газрын тостой холбогдсон үйл ажиллагаанд шаардагдах бүхий л хөрөнгийг чөлөөтэй хөрвөх валютаар гаргаж, эдгээр валютыг 17.1-д заасан ханшаар Монгол Улсын арилжааны банкаар дамжуулан төгрөгөөр солих;
- b) Хилийн чанадад мөнгөн хөрөнгөтэй байж, үүнийг чөлөөтэй зарцуулах;
- c) Өөрт ногдох газрын тосыг экспортлох, худалдах буюу солих замаар хилийн чанадад олсон бүх орлогоо гадаадад байлгах, чөлөөтэй зарцуулах;
- d) Монгол төгрөгийг 17.1-д заасан ханшаар Монгол Улсын арилжааны банкаар дамжуулан гадаад валютаар солих, өөрт ногдох газрын тосыг худалдах, солих, экспортлох замаар Монгол Улсад олсон бүх орлогоо гадаадад гаргах буюу чөлөөтэй зарцуулах;
- e) Өөрийн туслан гүйцэтгэгч буюу гадаад орны харьяат ажиллагсадад Монгол Улсад буюу бусад оронд гадаад валютаар цалин олгоно. Эдгээр ажиллагсад нь зөвхөн хувийн амьжиргааны хэрэгцээг хангах хэмжээний гадаад валютыг Монголд оруулах;
- f) Энэ гэрээний дагуу Засгийн газрын төлөөлөгчид буюу Монгол Улсад төлөх төлбөр, эсвэл газрын тостой холбогдсон үйл ажиллагаанд шаардагдах бусад төлбөрийг гүйцэтгэхийн тулд Гэрээлэгчийн сонгож авсан Монголын аль нэг банкинд валютын нэг буюу хэд хэдэн данстай байх.

17.4 ГЭРЭЭНИЙ ДАГУУ ГҮЙЦЭТГЭХ ТӨЛБӨР

Хэрэв өөрөөр тохиролцоогүй бол Талууд энэ гэрээний дагуу гүйцэтгэх төлбөрийг АНУ-ын доллараар хийнэ.

АРВАН НАЙМДУГААР ЗҮЙЛ

МОНГОЛЫН ТУСЛАН ГҮЙЦЭТГЭГЧ, ЭД МАТЕРИАЛ БА АЖИЛЛАГСАД

18.1 МОНГОЛЫН ТУСЛАН ГҮЙЦЭТГЭГЧ, ЭД МАТЕРИАЛ БА АЖИЛЛАГСДЫГ СОНГОХ ТУХАЙ

Гэрээлэгч ба түүний туслан гүйцэтгэгчид нь:

а) Монгол Улсын туслан гүйцэтгэгчийн санал болгож буй үнэ, мэргэжлийн чадвар болон чанар нь олон улсын үзүүлэлттэй жишиж болох нөхцөлд юуны өмнө монголын Туслан гүйцэтгэгчийг сонгоно.

б) Монголд үйлдвэрлэсэн материал, тоног төхөөрөмж, техник хэрэгсэл болон өргөн хэрэглээний барааны үнэ, чанар, тэдгээрийг нийлүүлэх хугацаа нь гадаадаас авч болох материал, тоног төхөөрөмж, техник хэрэгсэл, өргөн хэрэглээний бараатай жишиж болох нөхцөлд Монголд үйлдвэрлэсэн зүйлийг сонгоно;

в) Ажиллагсдыг сонгон шалгаруулахдаа юуны өмнө зохих ёсны мэргэжилтэй монголын иргэдийг сонгож авахыг эрхэмлэн. Монгол Улсын хөдөлмөр эрхлэлтийн газраас зохих зөвшөөрөл авсны үндсэн дээр Гэрээлэгч нь чухал албан тушаалд өөрийн ажиллагсдыг ажиллуулах эрхтэй. АМГТХЭГ энэхүү зөвшөөрлийг авахад Гэрээлэгчид туслалцаа үзүүлнэ. Гэрээлэгч нь Монгол Улсын Туслан гүйцэтгэгч, Монголд үйлдвэрлэсэн бараа, материал болон Монгол Улсын ажиллагсдыг ашиглахын тулд Засгийн газрын төлөөлөгчөөс дэмжлэг туслалцаа үзүүлэхийг хүсч болох ба энэ зүйлийн дагуу Гэрээлэгчийн хүлээх үүрэг, нөхцлийг Засгийн газрын төлөөлөгчөөс Гэрээлэгчид урьдчилан мэдэгдсэн байхыг хүлээн зөвшөөрөв. Гэрээлэгч нь гэрээний дагуу үүрэгт ажлаа гүйцэтгэж яваад үйлдвэрлэлийн ослоор хөдөлмөрийн чадвараа тур буюу бүрмөсөн алдсан тохиолдолд ажиллагсадад хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэмжийг Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу төлнэ.

АРВАН ЕСДҮГЭЭР ЗҮЙЛ

ОНЦ БАЙДАЛ

19.1 ГАЗРЫН ТОСТОЙ ХОЛБОГДСОН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ГАРЧ БОЛОХ ОНЦ БАЙДАЛ

Гэрээлэгч нь онц байдал тохиолдоход авах шаардлагатай гэж үзсэн бүх арга хэмжээг авах ба энэ тухай Засгийн газрын төлөөлөгчид иэн даруй мэдэгдэнэ.

19.2 ҮНДЭСНИЙ ОНЦ БАЙДАЛ

- а) Үндэсний онц байдал бий болох тохиолдолд Монгол Улсын Засгийн газар нь Гэрээт талбайгаас олборлох Гэрээлэгчийн хуваарьт тосыг нөхөн төлөх нөхцөлтэйгээр бүхлээр нь буюу хэсэгчлэн энэхүү гэрээний 8.5 дугаар зүйлийн дагуу тогтоосон үнээр дайчлан авч болох бөгөөд олборлолтыг дээд хэмжээнд хүртэл нэмэгдүүлэхийг Гэрээлэгчээс шаардаж болно.
- б) Газрын тосыг ийнхүү дайчлан авах тухай асуудлаар саналаа илэрхийлэх боломжийг Гэрээлэгчид олгоно.
- в) Газрын тосны нөөцнөөс дайчлан авах явдал нь Монгол Улсын хууль, тогтоомжийн дагуу Гэрээлэгчид зохих ёсоор мэдэгдсэнд үндсэн дээр явагдах ба онц байдлыг зогсоох хүртэл хугацаанд хүчин төгөлдөр байна.
- г) Монгол Улсын Засгийн газар онц байдалтай холбогдон Гэрээлэгчид учирсан бүх хохирлыг барагдуулна.

ХОРЬДУГЛАР ЗҮЙЛ

ДАВАГДАШГҮЙ ХҮЧИН ЗҮЙЛ

20.1 Энэхүү 20 дугаар зүйлд дурьдсан “Давагдашгүй хүчин зүйл” гэдэг ойлголтод дараах зүйл багтана. Үүнд: гал түймэр, гоц халдварт өвчний тархалт, гарцаагүй тохиолдсон осол, зарласан ба зарлаагүй дайн, ажил хаялт, эмх замбараагүй байдал, үер, хүчтэй салхи шуурга, газар хөдлөлт болон байгалийн бусад гамшигт үзэгдэл, үймээн самуун, бослого хөдөлгөөн зэрэг Гэрээлэгч талын хяналтаас гарсан, үүргээ биелүүлэхэд /мөнгөн төлбөр төлөхөөс бусад үүрэг/ саад учруулах аливаа үйл явдал, үзэгдэл багтана.

20.2 Давагдашгүй хүчин зүйлийн улмаас Гэрээлэгч нь ямар нэгэн үүргээ бислуулээгүй, гэрээнд заасан ямар нэгэн эрхээ зээлж чадаагүй бол үйл ажиллагаагаа сэргээж үргэлжлүүлэх, эхлүүлэхэд шаардагдах үндэслэлтэй хугацааг нэмж, гэрээнд заасан болон тухайн Хайгуул, Олборлолтын үе дээр нэмж тооцино. Давагдашгүй хүчин зүйлээс шалтгаалсан үйлдлийг энэхүү Гэрээг зөрчсөн гэж үзэхгүй.

20.3 Хэрэв нэг буюу түүнээс дээш үр ашигтай нээлтээс олборлож байсан буюу олборлож болох байсан газрын тосны үйлдвэрлэлийг давагдашгүй хүчин зүйлийн улмаас зогсоосон, хязгаарласан бол олборлож болох байсан хэмжээнд хүргэхийн тулд шаардагдах хугацааг 5 дугаар зүйлд заасан хугацаан дээр нэмж тооцино. Энэхүү заалтыг хэрэгжүүлэх зорилгоор хэрэглэсэн “хэмжээ” гэсэн ойлголт нь олборлолтын үйл ажиллагааг зогсоогоогүй тохиолдолд үр ашигтай нээлтийн хүрээнд өрөмдсөн цооногуудаас олон улсын газрын тосны үйлдвэрлэлд хэвшсэн практикийн дагуу олборлож болох байсан газрын тосны нийт хэмжээг хэлнэ. Гэрээлэгч нь энд заасан олборлох ёстой газрын тосны нийт хэмжээний тухай Засгийн газрын төлөөлөгчид Хуанлийн жил бүрийн дараа ер (90) хоногийн дотор мэдэгдэж байна.

ХОРИН НЭГДҮГЭЭР ЗҮЙЛ

ГЭРЭЭГ ДУУСГАВАР БОЛГОХ

- 21.1 Хэрэв энэ гэрээнд гарын үсэг зурсны дараа 180 хоногийн дотор гэрээ хүчин төгөлдөр болохгүй бол Гэрээлэгч нь Засгийн газрын төлөөлөгчид гэрээг дуусгавар болгох тухай мэдэгдэж болно.
- 21.2 Хэрэв Гэрээлэгч нь гэрээ хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш 120 хоногийн дотор хайгуулын үйл ажиллагаагаа эхлээгүй бол Засгийн газрын төлөөлөгч нь энэхүү гэрээг дуусгавар болгоно.
- 21.3 Хэрэв Гэрээлэгч эд материалын зөрчил гаргасан болон уг зөрчлийг энэ Гэрээнд заасан хугацаанд арилгаагүй буюу арилгаж эхлээгүй бол АМГТХЭГ энэхүү Гэрээг дуусгавар болгох эрхтэй.
- 21.4 Хэрэв АМГТХЭГ 21.2, 21.3 дугаар зүйлийн дагуу эрхээ хэрэгжүүлэхээр шийдвэрлэвэл Засгийн газрын төлөөлөгч Гэрээлэгчид бичгээр мэдэгдэл өгнө. Мэдэгдэл өгснөөс хойш 90 хоногийн дотор Гэрээлэгч нь дээрх зөрчлийг арилгаагүй буюу арилгаж эхлээгүй ба зөрчлийг арилгахад нь давагдашгүй хүчин зүйл саад болоогүй, тасалдуулаагүй бол энэ гэрээг дуусгавар болгох шийдвэрийг АМГТХЭГ гаргана. Ийм шийдвэрийн эсрэг Гэрээлэгч нь 22 дугаар зүйл дэх арбитрийн тухай заалтыг ашиглах эрхтгэй. Гэрээлэгч ийнхүү Арбитрийн шүүхэд ханцсан тохиолдолд гэрээг цуцлах тухай шийдвэр Арбитрийн шүүхийн эцсийн шийдвэр гарах хүртэлх хугацаанд хүчин төгөлдөр бус байна. 21.2, 21.3 дугаар зүйлийн дагуу Гэрээг

- цуцалсан тохиолдолд Гэрээлэгч нь тухайн гэрээт жилд хийгдээгүй наад захын ажил үүрэгт ногдох толбөрийг Засгийн газрын төлөөлогчид төлнө.
- 21.5 Хэрэв АМГТХЭГ эсвэл Засгийн газрын төлөөлөгч эд материалын зөрчил гаргасан болон уг зөрчлийг энэ Гэрээнд заасан хугацаанд арилгаагүй буюу арилгаж эхлээгүй бол Гэрээлэгч энэхүү Гэрээг дуусгавар болгох эрхтэй.
- 21.6 Хэрэв Гэрээлэгч 21.5 дугаар зүйлийн дагуу эрхээ хэрэгжүүлэхээр шийдвэрлэвэл АМГТХЭГ-т бичгээр мэдэгдэл өгнө. Мэдэгдэл өгснөөс хойш 90 хоногийн дотор АМГТХЭГ дээрх зөрчлийг арилгаагүй буюу арилгаж эхлээгүй ба зөрчлийг арилгахад нь давагдашгүй хүчин зүйл саад болоогүй, тасалдуулаагүй бол энэ гэрээг дуусгавар болгох шийдвэрийг Гэрээлэгч гаргана. Ийм шийдвэрийн эсрэг АМГТХЭГ 22 дугаар зүйл дэх арбитрийн тухай заалтыг ашиглах эрхтэй. АМГТХЭГ ийнхүү Арбитрийн шүүхэд хандсан тохиолдолд гэрээг цуцлах тухай шийдвэр Арбитрийн шүүхийн эцсийн шийдвэр гарах хүртэл хүчин төгөлдөр бус байна. Ийнхүү Гэрээг дуусгавар болсон тохиолдолд Гэрээлэгч нь тухайн гэрээт жилийн ажил үүргийг гүйцэтгэх эсвэл наад захын ажил үүргийн төлбөрийг төлөх үүргийг хүлээхгүй.
- 21.7 Гэрээ дуусгавар болсны дараа Гэрээлэгч нь 15.1-д зааснаас бусад газрын тостой холбогдсон үйл ажиллагаа явуулахаа хэрэглэхээр түрээслэлсэн буюу өөрийн бүрэн эзэмшлийн зөөверлөж болох бүх эд хөрөнгөө Монгол Улсын нутаг дэвсгэрээс гаргах эрхтэй.

ХОРИНХОЁРДУГААР ЗҮЙЛ

МАРГААНЫГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ, ХҮЛЭЭЛГЭХ ХАРИУЦЛАГА

- 22.1 Гэрээнд оролцогч талуудын хооронд уг гэрээний заалттай холбогдон гарах (түүнийг хэрэгжүүлэх, тайлбарлах, хэрэглэх, хугацаа дусах, цуцлах эсвэл сунгах) аливаа маргааныг эв зүйгээр шийдвэрлээгүй бол маргааныг НҮБ-ын Олон улсын худалдааны эрхийн баримт бичиг боловсруулах комиссын /UNCITRAL/ Арбитрийн дүрмийн дагуу шийдвэрлүүлнэ. Таван сая /5.000.000/ ам. доллараас бага үнийн дүнтэй холбогдон гарсан аливаа маргааныг Олон улсын худалдааны танхимын дэргэдэх Олон улсын арбитрийн шүүхээс томилсон арбиторчоор шийдвэрлүүлнэ. Таван сая /5.000.000/ ам. доллартой тэнцүү эсвэл түүнээс их үнийн дүнтэй холбогдон гарсан аливаа маргааныг гурван арбиторчоор шийдвэрлүүлнэ. Энэ нехцэлд талууд тус бүр нэг арбиторчийг томилох бөгөөд гуравдах арбиторчийг Олон улсын худалдааны танхимын дэргэдэх Олон улсын арбитрийн шүүхээс томилно. Хэрэв энэхүү гэрээнд хоёроос илүү оролцогч тал байвал гурван арбиторчийг бүгдийг Олон улсын худалдааны танхимын дэргэдэх Олон улсын арбитрийн шүүх томилно.
- 22.2 Хэрэв Гэрээлэгч талууд Газрын тосны тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийн аливаа заалтыг зөрчсөн үйл ажиллагаа явуулж аж ахуйн изгж, байгууллага, хувь хүмүүс хохирол учруулсан бол холбогдох хууль тогтоомжийн дагуу хариушлага хүлээн.
- 22.3 Гэрээлэгч талууд нь гэрээний үүргийг зөрчсеноос учирсан хохирлыг /гэрээнд буюу Монгол Улсын хууль тогтоомжид заасны дагуу/ гэм буруутай тал нь нөхөн төлнө.

- 22.4 Арбитрийн шүүх ажиллагаанд шаардлагатай аливаа хуул зүйн процесс эсвэл мэдэгдлийг энхүү Гэрээний 23 дугаар зүйлд заасны дагуу илгээсэн тохиолдолд эдгээр баримт, мэдэгдлийг албан ёсны хүчин төгөлдөр гэж тооцно.
- 22.5 Аль нэг талын гаргасан өргөдлийн дагуу арбитрийн шуух дор дурдсан хамгаалах эсвэл түр арга хэмжээг авахыг Талууд зөвшөөрөв. Үүнд: Маргааны хэлэлцэх асуудал эсвэл маргаантай холбогдуулан гаргасан аливаа нэмэлт гомдолтой холбогдсон арбитрийн ажиллагааг үр дүнтэй явуулах, үргэлжлүүлэн гүйцэтгэх хэрэгтэй гэж үзэх, энхүү гэрээ болон 22 дугаар зүйлд арбитрийн ажиллагааг тохиролцсоны дагуу аль нэг талын эрх ашиг, сонирхлыг хамгаалахын тулд аль ч талыг гомдол гаргах эсвэл үргэлжлүүлэн заргалдахаас татгалзахыг шаардсан шийдвэр гаргах болон хууль тогтоомжоор хориглоогүй тохиолдолд тухайн хэлэлцэх асуудалтай холбогдуулан хэрэглэж болох хууль, тогтоомж байвал арбитрийн үйл ажиллагаатай шууд болон шууд бусад холбогдсон бусад шүүхийн аливаа үйлдэл, нэхэмжэлийг буцаан татах буюу дуусгавар болгох.
- 22 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу эхэлсэн аливаа арбитрын ажиллагааг эцэслэн дуусах болон давж заалдах эрх байгаа бол тэрхүү эрхийг барагдуулах хүртэл талууд аливаа ажиллагааг үүсгэхгүй, гомдол гаргахгүй, харьалах аливаа шүүхэд эсвэл шүүх эрх мэдлийн буюу бусад эрх бүхий байгууллагад энхүү 22 дугаар зүйлд заасан маргааныг хянан шийдвэрлэх, энэ Гэрээнээс буюу түүнтэй холбогдон үүсэх аливаа маргааны талаар нэхэмжлэл гаргахгүй гэж буцалтгүй хүлээн зөвшөөрөв. Үүний дотор арбитрийн шүүхээс гаргасан аливаа шийдвэрийг эсвэл ажиллагааныхаа явцад гаргасан аливаа процессын шинжтэй шийдвэрийг давж заалдах, тэдгээрт нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болгох талаар авсан ажиллагаа, түүнчлэн 22 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу байгуулсан арбитрын аливаа ажиллагааг цаашид үргэлжлэхийг шууд ба шууд бусаар хязгаарласан, зогсоосон бусад шүүхийн шийдвэр болон шүүхийн хориг тавих замаар хохирлыг нехөн төлүүлэх болон бусад тогтоол гаргуулах үйл ажиллагаа орно. Харин арбитрийн шүүхийн аливаа эцсийн болон процессын шийдвэрийг зөвхөн хүлээн зөвшөөрөх эсвэл биелүүлэх зорилгоор явуулсан ажиллагаа үүнд хамаарахгүй.
- 22.6 Аливаа тал нь одоо болон цаашид шаардаж байгаа өөрийн халдашгүй бүрэн эрх болон эд хөрөнгенөөс энхүү Гэрээгээр хэрэглэж болох улсын хууль тогтоомжийн хүрээнд дээрх эрхээсээ татгалзана. Ийнхүү татгалзах нь дараах халдашгүй байдалд хамаарна: (i) энхүү Гэрээнд заасан ёсоор явуулсан аливаа шинжээч томилох, зуучлах, эсвэл арбитрийн ажиллагаа, (ii) энхүү Гэрээнд заасан ёсоор шинжээч томилох, зуучлах, эсвэл арбитрийн ажиллагаанд туслалцаа үзүүлэх аливаа шүүн таслах, захиргааны болон бусад ажиллагаа, (iii) энхүү Гэрээнд заасан ёсоор явуулсан шинжээч томилох, зуучлах, арбитрийн эсвэл аливаа шүүн таслах болон захиргааны ажиллагаанаас гарсан шийдвэр, тохиролцоо, захирамж, процессын мэдүүлэг, гүйцэтгэх тогтоол, эсвэл үргийн гүйцэтгэлийг хангах зорилгоор эд хөрөнгө хураан авах тухай захирамж (үүний дотор шүүхийн шийдвэр гарахаас өмнөх үсийн захирамж мөн орно)-ийг батлах, гүйцэтгэлийг хангах, биелүүлэх зэрэг аливаа хүчин чармайлт. Тал бүрийн дурдсан эрх, үүрэг нь Засгийн газрын бус худалдааны чанартай гэдгийг талууд хүлээн зөвшөөрөв.
- 22.5 Арбитрийн үйл ажиллагаа Сингапур Улсад англи хэлээр явагдах бөгөөд арбиторч(ид) англи хэлийг бүрэн эзэмшсэн байна.

ХОРИНГУРАВДУГААР ЗҮЙЛ

МЭДЭГДЭЛ

23.1 Гэрээлгчид бичгээр өгөх мэдэгдэл нь дараах тохиолдолд хүчин төгөлдөр байна.
Үүнд:

- 23.3 дугаар зүйлд заасан Гэрээлэгчийн удирдах төвд эсвэл Гэрээлэгч өөрийн төлөөлөгчийн газраа Монголд нээсний дараа уг газарт факсаар явуулж, түүнийг хүлээн авсныг факс баталгаажуулсан байх эсвэл хүлээн авсан тухай хариу авсан байх.
- Гэрээлэгчийн төлөөлөгчид хүргүүлж, түүнийг хүлээн авсан нотолгоог авсан байх, эсвэл тийм мэдэгдлийг биечлэн хүргэх тохиолдолд Гэрээлэгчийн төлөөлөгч буюу түүний эрх мэдэл бүхий төлөөлөгчдийн нэгнээс нь хүлээн авсан тухай хариу авсан,

23.2 АМГТХЭГ болон Засгийн газрын төлөөлөгчид бичгээр өгөх мэдэгдэл нь дараахь тохиолдолд хүчин төгөлдөр байна. Үүнд :

- 23.3 дугаар зүйлд заасан АМГТХЭГ-ын удирдах төвд факсаар явуулж, түүнийг хүлээн авсан тухай хариу эсвэл түүнийг хүлээн авсныг факс баталгаажуулсан байх.
- Засгийн газрын төлөөлөгчид хүргүүлж, түүнийг хүлээж авсан нотолгоог авсан байх, эсвэл тийм мэдээллийг биечлэн хүргэх тохиолдолд Засгийн газрын төлөөлөгч буюу түүний эрх мэдэл бүхий төлөөлөгчдийн нэгнээс мэдэгдлийг хүлээн авсан тухай хариу авсан байх зэрэг болно.

23.3 Дээрх 23.1 ба 23.2-т заасан мэдэгдлийг дараах хаягаар илгээнэ. Үүнд :

a) АМГТХЭГ-т :

Ашигт малтмал, газрын тосны хэрэг эрхлэх газар
Монгол Улс, Улаанбаатар хот, 211037
Үйлдвэрчний гудамж
Ш/Х 37/81

Хуулбарыг Засгийн газрын төлөөлөгчид:

Ашигт малтмал, газрын тосны хэрэг эрхлэх газар
Монгол Улс, 211238 Улаанбаатар хот,
Барилгачдын талбай 3,
Төрийн өмчийн байр-5, 38-р шуудан холбоо

Хэнд: Лувсанвандан Болд
Албан тушаал: Дарга
Факс: (976-11) 327307, Утас: (976-11) 310370
E-mail: mram@magicnet.mn

b) Гэрээлэгчийн төлөөлөгч :
Shaman Resources Ltd.

Suite 4 Temple Building
Main & Prince William Streets
Charlestown, Nevis
West Indies
Attention: President
Fax: 869-469-7042 Tel: 869-469-7040

Хуулбарыг:
Shaman Resources Ltd.
Suite B-2015 Burrard Street
Vancouver, BC

Attention: President
Fax: 604-608-9024 Tel: 608-738-0100
Bennet Jones LLP
4500 Bankers Hall East
855 – 2nd Street SW

Calgary, AB T2P 4K7
Attention: Mr. Angus Mitchel
Fax: 403-265-7219 Tel: 403-298-3023

- 23.4 Талууд нөгөө талдаа 30 хоногийн өмнө урьдчилан мэдэгдсэний үндсэн дээр мэдэгдэл хүлээж авах хаягаа оөрчилж болно.
- 23.5 Аль нэг тал нь нөгөө талын мэдэгдлийг хүлээж авахаас татгалзах буюу хүлээж авах боломжгүй тохиолдолд нөгөө талын эрх ашиг ямар нэг байдлаар хохирох ёсгүй.

ХОРИНДӨРӨВДҮГЭЭР ЗҮЙЛ

ДААТГАЛ

- 24.1 Энэхүү гэрээний дагуу Гэрээлэгчийн явуулж буй бүхий л үйл ажиллагааны хувьд Гэрээлэгч холбогдох хууль тогтоомжийн дагуу даатгуулах үүрэгтэй.
- 24.2 Гэрээлэгч нь өөрийн Туслан гүйцэтгэгчдийг нэгэн адил даатгуулсан байхыг шаардах бөгөөд Гэрээлэгчийн шаардлагатай гэж үзсэн нэмэлт даатгал нь даатгалын гэрчилгээгээр баталгаажуулагдсан байх болно.
- 24.3 Гэрээлэгч болон Туслан гүйцэтгэгч нь энэхүү Гэрээний дагуух газрын тостой холбогдсон үйл ажиллагаагаа даатгуулахдаа Монголын даатгалын компанийд даатгуулна.
- 24.4 Хэрэв Монголын даатгалын компани ийм даатгалыг хийх чадваргүй буюу татгалзвал Гэрээлэгч нь Засгийн газрын төлөөлөгчтэй тохиролцсоны үндсэн дээр өөр бусад хувилбарыг сонгож болно.

ХОРИНТАВДУГААР ЗҮЙЛ

ЕРӨНХИЙ ЗААЛТ

- 25.1 УИВСРАЛТУУД

Хавсралт А, Б, В, Г - нь энэхүү Гэрээний салшгүй бүрэлдэхүүн хэсэг болно.

25.2 ХУУЛЬ

Энэхүү Гэрээ нь Монгол Улсын хууль тогтоомж болон олон улсын эрх зүй, Монгол улсын нэгдсэн орсон олон улсын гэрээний зарчимтай нийцсэн байна.

25.3 САЙН САНАА

Талууд энэхүү гэрээний дагуу хоорондын харилцаагаа сайн санааны зарчимд үндэслэж, нэгдмэл зорилтоо хэрэгжүүлэхийн төлөө хамтран ажиллаж, гарч болох аливаа үл ойлголцол, маргааныг эв зүйгээр зохицуулан шийдвэрлэхийг эрмэлзэнэ.


25.4 ГЭРЭЭНИЙ ХЭЛ

Гэрээг монгол, англи хэлээр үйлдсэн бөгөөд эх бичвэрүүдийг тайлбарлахад хоорондоо зөрчилдвэл англи хэлний хувилбар нь шийдвэрлэх хүчинтэй болно.

25.5 ГЭРСЭХҮЧИН ТӨГӨЛДӨР БОЛОХ

Энэхүү гэрээ нь Засгийн газраас баталсан өдрөөс хүчин төгөлдөр үйлчилийн АМГТХЭГ энэхүү гэрээг шуурхай батлуулах талаар чармайн ажиллана.

АШИГТ МАЛТМАЛ, ГАЗРЫН ТОСНЫ
ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫГ ТӨЛӨӨЛЖ:



АМГТХЭГ-ЫН ДАРГА Л. БОЛД

ГЭРЭЭЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:



ЕРӨНХИЙЛӨГЧ ЖОРЖ СТАБОС



АШИГТ МАЛТМАЛ, ГАЗРЫН ТОСНЫ ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР,
 КАНАД УЛСЫН "ШАМАН РЕСУРСЭС ЛТД" КОМПАНИЙН
 ХООРОНД БАЙГУУЛСАН БҮТЭЭГДЭХҮҮН
 ХУВААХ ГЭРЭЭНИЙ

ХАВСРАЛТ "А"

ГЭРЭЭТ ТАЛБАЙ

Энэхүү хавсралт "А" нь Ашигт малтмал, газрын тосны хэрэг эрхлэх газар, Канад Улсын "Шаман Ресурсес ЛТД" компанийн хооронд 2007 оны ... дугаар сарын - ны өдөр байгуулсан Бүтээгдэхүүн хуваах гэрээний бүрэлдэхүүн хэсэг нь болно.

ГЭРЭЭТ ТАЛБАЙН ЗУРАГ (ард хавсаргав)



АШИГТ МАЛТМАЛ, ГАЗРЫН ТОСНЫ ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР,
КАНАД УЛСЫН "ШАМАН РЕСУРСЭС ЛТД" КОМПАНИЙН
ХООРОНД БАЙГУУЛСАН БҮТЭЭГДЭХҮҮН
ХУВААХ ГЭРЭЭНИЙ

ХАВСРАЛТ "Б"

ГЭРЭЭТ ТАЛБАЙ

Энэхүү хавсралт "Б" нь Ашигт малтмал, газрын тосны хэрэг эрхлэх газар, Канад Улсын "Шаман Ресурсес ЛТД" компанийн хооронд 2007 оны ... дугаар сарын - ны өдөр байгуулсан Бүтээгдэхүүн хуваах гэрээний бүрэлдэхүүн хэсэг нь болно.

ГЭРЭЭТ ТАЛБАЙН БАЙРЛАЛ

1. Талбайн нэр	Нялга - XVI
2. Талбайн хэмжээ	16839 кв.км.
3. Солбилцолын цэг	

Дугаар	Үртраг	Өргөрөг
1	107° 29'59"	46° 40'00"
2	107° 29'59"	47° 00'00"
3	108° 00'00"	47° 00'00"
4	108° 00'00"	47° 10'00"
5	108° 29'59"	47° 10'00"
6	108° 29'59"	47° 20'00"
7	109° 00'00"	47° 20'00"
8	109° 00'00"	47° 30'00"
9	109° 29'59"	47° 30'00"
10	109° 29'59"	47° 20'00"
11	111° 00'00"	47° 20'00"
12	111° 00'00"	47° 10'00"
13	110° 29'58"	47° 10'00"
14	110° 29'58"	46° 40'00"
15	108° 29'58"	46° 40'00"
16	108° 29'58"	46° 30'00"
17	108° 00'00"	46° 30'00"
18	108° 00'00"	46° 40'00"

АШИГТ МАЛТМАЛ, ГАЗРЫН ТОСНЫ ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР,
КАНАД УЛСЫН “ШАМАН РЕСУРСЭС ЛТД“ КОМПАНИЙН
ХООРООНД НЯЛГА -XVI ТАЛБАЙД БАЙГУУЛСАН
БҮТЭЭГДЭХҮҮН ХУВААХ ГЭРЭЭНИЙ

ХАВСРАЛТ “Г”

БҮРТГЭЛ ТООЦООНЫ ЖУРАМ

НЭГДҮГЭЭР ЗҮЙЛ

ЕРӨНХИЙ ЗААЛТУУД

1. НЭР ТОМЬЁО

_____ оны _____ дүгээр сарын _____-ний өдрийн Бүтээгдэхүүн хуваах гэрээний 2 дугаар зүйлд тодорхойлсон нэр томьёонууд энэхүү Бүртгэл тооцооны журманд хамаарах бөгөөд адил утга агуулна.

2. БҮРТГЭЛ ТООЦООНЫ ЖУРМЫН ЗОРИЛГО БОЛОН
БАРИМТ БИЧГИЙН ДАВАМГАЙЛАХ БАЙДАЛ

Гэрээний дагуу зарцуулсан зардал, эд хөрөнгийн өртгийг тооцоолох үнэн зөв аргыг тодорхойлоход бүртгэл тооцооны журмын зорилго нь оршино. Хэрэв энэхүү арга нь АМГТХЭГ болон Гэрээлэгчийн хувьд шударга бус, зохисгүй байна гэж үзвэл талууд тохиролцон зохих өөрчлөлтүүдийг оруулна.

Энэхүү бүртгэл тооцооны журмын заалтууд гэрээний заалттай үл тохирох буюу зөрчилдөх аливаа тохиолдолд гэрээний заалтуудыг баримтлана.

3. ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАНГУУД

- a) Гэрээлэгч нь АМГТХЭГ-т хайгуулын үеийн туршид хуанлийн улирал бүрийн эцсээс хойш гуч (30) хоногийн дотор дараах тайлангуудыг шилжүүлнэ. Үүнд:
1. санхүүгийн нарийвчилсан тайлан, ажил гүйлгээний жагсаалт;
 2. орлого зарлагын тайлан;
 3. дээрх тайлангуудын дунг хуримтлагдсан дүнгээр бэлтгэх.

Эдгээр тайлангууд нь энэхүү Бүртгэл тооцооны журмын дагуу хийгдсэн байна. Жилийн тайланг жил бүр хуанлийн жил дууссанас хойш жар (60) хоногийн дотор гаргаж өгнө.

- б) Олборлолтын үед Гэрээлэгч нь АМГТХЭГ-т хуанлийн улирал бурийг дууссанаас хойш гуч (30) хоногийн дотор буюу олборлолтын тайлангийн хувьд дараагийн сар болгоны эхний долоо (7) хоногийн дотор дараах тайлангуудыг гаргаж өгнө. Үүнд:
1. олборлолтын тайлан;
 2. олборлолтын тайлангийн үнэлгээ;
 3. өртөг нөхөлтийн тайлан
 4. орлого зарлагын тайлан;
 5. хуваах тос болон тэнцвэржүүлэлтийн тайлан;
 6. санхүүгийн нарийвчилсан тайлан, ажил гүйлгээний жагсаалт;
 7. дээрх тайлангуудын дүнг хуримтлагдсан дүнгээр бэлтгэх.

Эдгээр тайлангууд нь энэхүү бүртгэл тооцооны журмын дагуу хийгдсэн байна. Гэрээлэгч нь эдгээрийг нэгтгэсэн жилийн тайланг жил бүр Хуанлийн жил дууссанаас хойш жар (60) хоногийн дотор гаргаж өгнө.

4. САНХҮҮГИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТ

- а) Гэрээний 13.3 дугаар зүйлд заасны дагуу шалгалт хийхдээ, Гэрээлэгчийн санхүүгийн данс, дансны бичилт, бараа материалын бүртгэл ба бараа материал, ваучер, цалингийн төлбөр, нэхэмжлэх, Гэрээнд шууд буюу шууд бусаар хамрагдах аливаа төрлийн гэрээ, туслан гүйцэтгэх гэрээ, бусад баримт бичиг, бичилтүүд зэрэг газрын тосны үйл ажиллагааны талаарх бүхий л төлбөр тооцоог шаардлагатай үед, зохих үндэслэлийн дагуу шалгах эрхтэй.
- б) Түүнчлэн, тухайн шалгалтын дагуу Гэрээлэгчийн Монголд болон бусад улсад орших газрын тосны үйл ажиллагаатай холбогдох газрууд, бүх үйлдвэрлэлийн байр, байгууламж, агуулах болон конторт очиж, түүний дотор эдгээр үйл ажиллагаатай холбогдох ажилтантай уулзаж, шаардлагатай үед, зохих үндэслэлийн дагуу шалгах эрхтэй. Гадаадад хийгдэх санхүүгийн хяналт, шалгалттай холбогдон гарах зардлыг АМГТХЭГ хариуцна.

5. ВАЛИЮТ СОЛИХ

Гэрээлэгчийн газрын тостой холбогдох үйл ажиллагааны бүртгэл нь АНУ-ын доллараар хийгдэнэ. АНУ-ын доллараар гарсан бүх зардал нь зарцуулсан тоо хэмжээгээрээ бүртгэгдэнэ. Монгол улсын мөнгөн нэгжээр гаргасан зардлыг гэрээний 17 дугаар зүйлд заасны дагуу АНУ-ын доллард шилжүүлж, АНУ-ын доллараас бусад мөнгөн нэгжээр гарсан зардал нь тухайн валютыг Гэрээлэгчийн АНУ-ын долларын данснаас худалдан авсан тохиолдолд худалдан авсан үнээр АНУ-ын долларт шилжүүлэгдэх ба үүнээс бусад тохиолдолд Монгол Банкны албан ханшаар тооцно.

Монгол төгрөг болон АНУ-ын доллараас бусад валютыг АНУ-ын долларт шилжүүлсэн ханшаар бүртгэл хөтөлнө.

Аливаа болзошгүй алдагдлаас хамгаалах болон валют солилцооны талаар байгуулсан гэрээ, хэлэлцээр болон бусад адил төстэй гэрээ, хэлэлцээрийн улмаас үүссэн аливаа алдагдал, ашгаас бусад валют солилцооны зоруулгээс үүссэн ашиг, алдагдлыг зохих данснуудад тусгана.

6. БҮРТГЭЛ

Гэрээлэгч нь бүртгэлийг Англи хэл дээр холбогдох хууль тогтоомж болон олон улсын газрын тосны салбарт хэвшсэн нягтлан бодох бүртгэлийн нийтлэг зарчмуудын дагуу хөтөлнө.

7. БҮРТГЭЛИЙН ЖУРМЫГ ХЯНАХ

Энэхүү Бүртгэлийн журмыг Гэрээлэгч, АМГТХЭГ хоёр бичгээр харилцан тохиролцсоны үндсэн дээр ирээдүйн үйл ажиллагааг зохицуулахаар үе үе шинэчлэн өөрчилж болно.

8. БҮРТГЭЛИЙН НАРИЙВЧИЛСАН АРГАЧЛАЛ

Гэрээ хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш ер (90) хоногийн дотор Гэрээлэгч нь Гэрээ болон энэхүү бүртгэл тооцооны журмын дагуу боловсруулсан дансны гүйлгээний бүдүүвч, зардлын нарийвчилсан ангилаал, баримтлагдах зардлын төвийн нарийвчлан тодорхойлсон хэлбэр, үйл ажиллагааны бичлэг болон бүртгэлийн аргачлалын талаарх саналыг АМГТХЭГ-т ирүүлж хэлэлцэнэ. Энэхүү аргачлалыг олон улсын газрын тосны салбарт хэвшсэн зарчмын дагуу боловсруулна. Ийнхүү хэлэлцсэний дагуу Засгийн Газрын төлөөлөгчийн зөвшөөрснөөр Гэрээлэгч нь цаашид ашиглагдах дансны гүйлгээний бүдүүвч, зааварчлагыг боловсруулж АМГТХЭГ-т гаргаж өгнө.

ХОЁРДУГААР ЗҮЙЛ ЗАРДАЛ, ОРЛОГО

1. ЗАРДАЛ

Гэрээлэгч нь Гэрээний дагуу дараах зардлуудыг хариуцаж шууд төлөх бөгөөд эдгээр зардлуудыг Гэрээний 8 дугаар зүйлийн дагуу Гэрээлэгч ангилж, нөхөн авна.

a) Хөдөлмөр эрхлэлт

1. Монголд ажиллаж буй Гэрээлэгчийн ажиллагсдын цалин хөлсөнд амралт, томилолт, өвчлөлт, хөдөлмөрийн чадвар алдахад олгох нэмэлтүүд орно.
2. Монголд ажиллаж буй гадаад ажиллагсадын цалин хөлсөнд хамарагдах амьжиргааны, орон байрны болон бусад хөнгөлөлтүүд, монгол ажиллагсдын цалин хөлсөнд хамарагдах шагнал, илүү цагийн болон бусад хөнгөлөлтүүд.
3. Татварын хуулийн дагуу болон холбогдох хууль, тогтоомжийн дагуу Засгийн газрын харьяа байгууллагаас ногдуулсан Гэрээлэгчийн Монголд ажиллаж буй ажиллагсадын цалин хөлсөнд хамарагдах хураамж, зардлууд.

b) Ажиллагсадад үзүүлэх хөнгөлөлт, олгох тэтгэвэр, тэтгэмж

Гэрээлэгчийн Монголд ажиллаж буй гадаад болон монгол ажиллагсадын цалин хөлсөнд хамарагдах ажиллагсдын амь болон нийгмийн даатгал, эмнэлэгт хэвтэж эмчлүүлэх, тэтгэвэр тэтгэмж олгох, чөлөөнд гарах, хувьцаа худалдаж авах, гадаадын иргэний төлөх татварыг тэнцвэржүүлэх зэрэг бусад хонгололтгэй холбогдон гарах өртог зардал.

Гэнэт халагдсаны тэтгэмжийг монгол ажиллагсадад цалингийн тогтмол хувиар тооцож холбогдох хууль, тогтоомжийн дагуу халагдсаны тэтгэмж олгох дээд хэмжээтэй тэнцэхээр төлнө. Гадаадын ажиллагсадад олгох халагдсаны тэтгэмж нь олон улсын газрын тосны салбарт хэвшсэн хэмжээгээр байна.

в) Материал, тоног төхөөрөмж ба сэлбэг хэрэгсэл

Гэрээлэгчийн худалдаж авсан, түрээсэлсэн буюу нийлүүлсэн материал, тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгсэл.

1. *Худалдаж авсан материал*

Гэрээлэгчийн худалдаж авсан материал, тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгслийн зардлыг тооцоходоо Гэрээлэгчийн жинхэнэ төлсөн үнээр эсвэл энэхүү 2 дугаар зүйлийн 3.а-д заасан үнэлгээний зарчмын дагуу үзүүлсэн бүх хөнгөлөлтийг нь хасаж тогтооно.

2. *Гэрээлэгч буюу салбар байгууллагаас нийлүүлсэн материал*

Гэрээлэгч нь аливаа материал, тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгслийг өөрийн буюу салбар байгууллагынхаа ноёцоөс авч нийлүүлнэ. Гэхдээ дээр дурдсан ноёцоөс нийлүүлсэн материалын үнэ нь даатгал, нийлүүлэлтийн адил нөхцөлд гуравдагч этгээдээс төсөөтэй эд зүйлийг худалдаж авч болох үнээс өндөр байх ёсгүй. Уг материал, тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгслийн үнэлгээг энэ 2 дахь зүйлийн 3.б-д заасны дагуу тогтооно.

3. *Баталгаа*

Гэрээлэгч нийлүүлж буй материал, тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгсэлдээ үйлдвэрлэгчийн буюу худалдагчийн баталгаанаас өөр ямар нэгэн баталгаа нэмж гаргахгүй бөгөөд хэрэв нийлүүлсэн материал гэмтэл согогтой байвал үйлдвэрлэгч буюу худалдагчаас Гэрээлэгчид зөрүүг нөхөн төлөх хүртэл үүнийг орлогод авахгүй.

4. *Түрээс*

Түрээсэлсэн материал, тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгслийн үнийг бодит төлсөн үнээр тооцино.

д) Тээвэрлэлт

Монголд ажиллаж буй Гэрээлэгчийн ажиллагдын ажлын аялал, тээврийн зардал болон газрын тостой холбогдсон үйл ажиллагаа явуулахад зайлшгүй шаардлагатай тоног төхөөрөмж, материал, сэлбэг хэрэгслийг тээвэрлэхэд гарсан зардал.

е) Үйлчилгээ

1. Гэрээлэгчийн гуравдагч этгээдээс зөвлөх, гэрээт үйлчилгээ болон хангамжаар үйлчлүүлэхтэй холбогдсон зардал нь тухайн гэрээт жилд 100.000 ам. доллараас хэтрэх төлөвтэй бол уг зардлын зөвшөөрлийг АМГТХЭГ-аас урьдчилан бичгээр авна. Уг зардал нь ижил төстэй ажил, үйлчилгээ үзүүлэх гадаадын болон Монголын байгуулагад төлөх зардалтай ойролцоо байна.
2. Монголд болон хилийн чанадад АМГТХЭГ, Гэрээлэгч буюу түүний салбар байгуулагаас лабораторийн шинжилгээ хийх, загварчлах, геофизикийн боловсруулалт, тайлал хийх, геологийн тайлал хийх, инженерийн болон мэдээллийн боловсруулалт зэрэг үйлчилгээний зардал. АМГТХЭГ-ын, Гэрээлэгчийн, түүний салбар байгууллагын бүрэн мэдлийн өмч болох тоног тохөөрөмж ашигласны төлбөр нь олон улсын газрын тосны салбарт тухайн үед мордож буй түрээсийн үнэлгээтэй дүйшүүцүүц байна.

Гэрээлэгч буюу түүний салбар байгууллагаас үзүүлсэн үйлчилгээ нь тухайн үед олон улсын газрын тосны салбарт мөрдеж буй үнэлгээтэй дүйцэхүйц байна. Уг зардал нь тухайн үйлчилгээг ижил нөхцөлөөр гүйцэтгэх бусад салбар байгууллага, гуравдагч этгээдэд гарах хэвийн зардлаас илүүгүй байна.

Шаардлагатай бол, тухайн үйлчилгээ, түүний зохион байгуулсаны зардал зэргийг баталсан баримтыг Гэрээлэгч, түүний салбар байгууллага, АМГТХЭГ-аар гаргуулан авна.

Гэрээлэгч, түүний салбар байгууллагаас үзүүлж байгаа үйлчилгээний зардал нь олон улсын газрын тосны салбарт газрын тосны компаниуд тэдгээрийн салбар байгууллагуудад төстэй үйлчилгээ үзүүлсний төлбөрт төлдөг зардлаас өндөр өртөгтэй бол АМГТХЭГ нь энхүү 2 дугаар зүйлийн 5 дугаар бүлгийн дагуу тухайн зардлыг өртөг нөхөлтөөс хасах эрх эдэлнэ.

ж) Хохирол болон алдагдал

Доорхи з) бүлгийн дагуу даатгалд хамрагдахаас бусад тохиолдолд газар хөдлөлт, гал түймэр, үер, шуурга, буюу бусад Гэрээлэгчээс хамаарахгүй шалтгааны улмаас учирсан хохирол, алдагдлыг нөхөн сэргээхэд гарах бүхий л зардал. Гэрээлэгч нь хохирол учирсан тухайгаа мэдээлэл авмагц АМГТХЭГ-т аль болох шуурхай бичгээр мэдэгдэнэ.

з) Даатгал, гомдол, зарга

Монгол Улсын хууль, тогтоомжийн дагуу буюу Гэрээлэгч, АМГТХЭГ-ын хооронд тохиролцсоны дагуу даатгалтай холбоотой зардалд хэрэглэгчдэд учирсан хохирлын хариуцлага, өмч хөрөнгийн гэмтэл болон бусад даатгал, мөн Гэрээлэгчийн ажиллагсад буюу хөндлөнгийн этгээдийн өмнө Гэрээлэгчийн хүлээх хариушлагын даатгалыг оруулна. Ийм даатгал буюу гомдол заргаас гарах зардлыг зохих зарлагын дансанд бүртгэнэ. Гэрээлэгч, АМГТХЭГ хоёрын тохиролцсоны дагуу аль нэг тодорхой аюул ослоос тусгайлан даатгуулаагүй бол гарсан аливаа алдагдал, зарга, шийтгэл, хохирол болон бусад зардлыг зохицуулан шийдвэр гаргуулахтай холбоотой Гэрээлэгчээс гарсан зардлыг дээрх ж) бүлгийн дагуу зарлагын зохих дансанд бүртгэнэ

и) Хээрийн анги, агуулах болон бусад байгууламж

Хээрийн ангиуд, агуулахууд, тээвэрлэлтийн болон холбооны систем, усан хангамж, зам болон бусад байгууламжуудийг хадгалж хамгаалах, тоноглох, ажиллуулахтай холбогдон Монгол Улсын нутаг дэвсгэрийн дотор гарч буй зардал.

к) Эрх зүйн зардал

Гэрээт талбай, газрын тостой холбогдсон үйл ажиллагаа, тоног төхөөрөмжийг хамгаалах, шүүх хурлын буюу хууль зүйн туслалцаа авсан, үүний дотор өмгөөлөгчийн хэлс, шагнал, зөвлөхийн цалин хөлсний тодорхой хувь, мөн Гэрээний дагуух газрын тостой холбогдсон үйл ажиллагааны талаар талууд болон аль нэгний нь эсрэг шийдвэр гарсантай холбоотой зардал, мөн газрын тостой холбогдсон үйл ажиллагаа буюу энэ гэрээний эсрэг чиглэсэн аливаа үйлдэл, гомдол, заргаас хамгаалах зорилгоор гэрээнд оролцогч талууд буюу аль нэг тал нь урьдчилан сэргийлэхээр авсан арга хэмжээний зардууд. Дээр дурдсан арга хэмжээг гэрээнд оролцогч талууд буюу аль нэгний нь хуульчид хэрэгжүүлсэн тохиолдолд тэдгээрт энхүү үйлчилгээ үзүүлсний зохих хэмжээний мөнгө төлнө.

л) Эх компанийн захиргааны зардал

1. /Цэр б)-д заасан Гэрээлэгчийн ажиллагсадын цалин хөлсийг оруулахгүйгээр Гэрээлэгчийн Монголд буюу гадаадад орших албан конторуудтай холбогdon гарах тардлыг Гэрээлэгчийн газрын тосны хайгуул, олборлолтын үйл ажиллагаанд жилд

зарцуулах зардлын хувиар дараах маягаар тооцно.

Гэрээлэгч нь дээр заасан хувиар улирал тутмын зардлыг урьдчилж бүртгэнэ.

2. Хээр бус албан конторт байнга ажилладаг Гэрээлэгчийн ажиллагсад, хяначид, мэргэжилтнүүд, захиргааны ажиллагсад болон Гэрээлэгчийн удирдлагын нийт ажиллагсадын цалин, бусад холбогдох зардал, түүнчлэн дээрх е) бүлэгт хамаарахгүй удирдан чиглүүлэх, зөвлөх, хянах болон бусад үйлчилгээнд хамаарах цалин, бусад зардлуудыг захиргааны зардалд оруулан, өөр бусад зардалд оруулан тооцохгүй.
3. Газрын тосны салбарт хэвшсэн аргачлалаар энэхүү захиргааны болон удирдлагын ажиллагсадын зардал нь улирал бүр үйл ажиллагааны, хайгуулын болон олборлолтын зардалд хуваарилагдана.

м) Татвар

Энэхүү Гэрээний дагуу Гэрээлэгч Монголд төлсөн орлогын татвараас бусад татвар болон хураамж.

н) Бусад зардлууд

Гэрээлэгчийн зарцуулсан буюу газрын тостой холбогдсон үйл ажиллагааг бүрэн хэрэгжүүлэхэд шаардагдах энэхүү 2 дугаар зүйлийн өмнөх заалтад тусгагдаагүй бусад зохих зардлууд. Энэхүү гэрээний дагуу Гэрээлэгчийн нөхөн төлөгдөх зардалд оруулахгүй байхаар тохиролцсон зардлуудыг үүнд хамааруулахгүй.

о) Хүү

Гэрээлэгчийн газрын тосны хайгуулын үйл ажиллагааг санхүүжүүлэхтэй холбогдсон санхүүжилтийн зардлын хүүг нөхөн төлөгдөх зардалд тооцохгүй. Харин банкны шимтгэл болох шилжүүлгийн болон валют солилцооны зардлын өргтгийг нөхөж болно. Харин олборлолтын үйл ажиллагаатай холбогдуулан хийгдсэн зах зээлийн хүүгийн түвшин дэх санхүүжилтийн зардал болон хүүг /Салбар нэгж, эх компани болон гуравдагч этгээдүүдээс авсан / нөхөн төлөгдөх зардалд тооцно.

ө) Цооног хаах зардал

Цооног хаах болон тухайн газрыг сэргээхтэй холбогдуулан Гэрээлэгчийн зарцуулсан зардал.

2. ОРЛОГО

Гэрээлэгч газрын тостой холбогдсон үйл ажиллагааны явцаас орсон орлогыг зохих дансанд бүртгэж авна. Уг орлого нь дараах ажил гүйлгээнээс бүрдэнэ:

а) Гомдол заргаас авсан орлого

Газрын тостой холбогдсон үйл ажиллагааны талаарх зарга, даатгалын орлого буюу хоронгэ.

б) Гуравдагч талын орлого

Өмч хөрөнгө ашиглуулсны, Гэрээлэгчээс үзүүлсэн үйлчилгээний буюу аливаа мэдээллийн телбөр хэлбэрээр гуравдагч талаас олсон орлого.

в) Тохиргоо бичилт

Өмнө нь дансанд бүртгэгдсэн гэмтэл согогтой материал, тоног төхөөрөмжид түүний нийлүүлэгч, үйлдвэрлэгчээс Гэрээлэгчид буцаан олгосон нехвер.

г) Буцааж төлсөн төлбөр

Өмнө нь дансанд бүртгэгдсэн байсан зардлаас Гэрээлэгчид буцаан төлсөн түрээс, нехөн төлбөр буюу бусад орлого.

д) Эд материал, тоног төхөөрөмж болон сэлбэг хэрэгслийг худалдах, экспортлох

Энэхүү гэрээнд тусгайлан заагаагүй бол Гэрээлэгч дансанд бүртгэлтэй байсан аливаа эд материал, тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгслийг салбар байгууллага, эсвэл бусад байгууллага, хувь хүнд худалдах, экспортлох буюу шилжүүлэх тохиолдолд уг шилжүүлгийн дүн бүртгэлд тусгагдсан байна.

3. ЭД МАТЕРИАЛ, ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ БОЛОН СЭЛБЭГ ХЭРЭГСЛИЙН ҮНЭЛГЭЭ

Тооцооны журмын 2 дугаар зүйлийн 1(г)-д заасны дагуу дансанд бүртгэлтэй эсвэл 2(д)-д зааснаар бүртгэлд тусгагдсан материал, тоног төхөрөемж болон сэлбэг хэрэгслийн үнэлгээ доорх зарчмаар хийгдэнэ. Үүнд:

1. Доорх (3.2) зүйлд өөрөөр заагаагүй бол Гэрээлэгчийн худалдан авсан эд материал, тоног төхөөрөмж болон сэлбэг хэрэгслийн үнэ нь эдгээртэй адил чанарын барааны олон улсын зах зээл дэх үнэ, худалдан авах хэлэлцээр байгуулсан тухайн үед олон улсын зах зээлд давамгайлж байсан нийлүүлэлтийн адил нөхцөлийн үнийн жишигтэй тохирч байх ёстой. Эд материал, тоног төхөөрөмж болон сэлбэг хэрэгслийн худалдан авах үнэ нь зохих тохиолдолд худалдааны болон бэлэн менгений хямдралтууд, нийлүүлэлтийн төлбөр, тээврийн болон хүргэх зардал, даатгал, татвар, гаалийн татвар, консулын төлбөрүүд болон бусад импортын бараанд ногдуулах төлбөрүүдийг урьд өмнө өөр тооцоонд оруулсан эсэхийг харгалzan үзэж хамруулна.
2. Салбар байгууллагуудаас худалдан авсан болон тэдэнд худалдсан эд материал, тоног төхөөрөмж болон сэлбэг хэрэгслийг доорх (а), (б)-д заасны дагуу үнэлнэ.
 - a) Шинэ эд материал, тоног төхөөрөмж болон сэлбэг хэрэгслүүд нь (А ангилал) Гэрээлэгчийн гэрээ байгуулах үеийн адил чанарын барааны олон улсын зах зээлийн үнэ, нийлүүлэлтийн адил нөхцөлийн үнийн жишигт нийцэж байх.
 - b) Хэрэглэж байсан эд материал, тоног төхөөрөмж болон сэлбэг хэрэгслүүд (Б, В ангилал).
- i) Эвдрэлгүй, гэмтэлгүй, үйлдвэрлэл үйлчилгээнд ашиглаж байгаа засвар үйлчилгээ шаардагдахгүй ашиглах боломжтой түүхий эд материал, тоног тохооремж болон сэлбэг хэрэгслүүд нь Б ангилалд хамрах бөгөөд дээрх (а)-д тодорхойлсон шинэ материал, тоног тохооромж болон сэлбэг хэрэгслүүдийн тухайн үеийн үнийн 75 хувиар (75%) үнэлэгдэнэ.

ii) Б ангилалд хамруулах боломжгүй материал, тоног төхөөрөмж болон сэлбэг хэрэгслүүд, гэхдээ:

- ♦ засвар үйлчилгээний дараа үндсэн зориулалтаар нь Б ангилалын дагуу хэрэглэж болох эд материал, тоног төхөөрөмж болон сэлбэг хэрэгслүүд эсвэл
- ♦ үндсэн зориулалтаар нь ашиглах боловч ерөнхийдөө засвар үйлчилгээ хийх боломжгүй эд материал, тоног төхөөрөмж болон сэлбэг хэрэгслүүд нь В ангилалд орох бегөөд дээрх (a)-д тодорхойлсон шинэ эд материал, тоног төхөөрөмж болон сэлбэг хэрэгслүүдийн тухайн үеийн үнийн 50 хувиар (50%) үнэлэгдэнэ. В ангиллын эд материал, тоног төхөөрөмж болон сэлбэг хэрэгслүүдийн үнэ засвар үйлчилгээний өртөг нийлзээд Б ангиллын эд материал, тоног төхөөрөмж болон сэлбэг хэрэгслүүдийн үнээс хэтрэхгүй байх нөхцөлд, засвар үйлчилгээний үнэ өртгийг засварлагдсан эд материал, тоног төхөөрөмж болон сэлбэг хэрэгслүүдэд оруулна.

iii) Б, В ангилалд орохгүй эд материал, тоног төхөөрөмж болон сэлбэг хэрэгслүүдийг хэрэглээтэй нь уялдуулж үнэлнэ.

4. ЗАРДЛЫН ТӨВҮҮД

Гэрээний дагуу нехен төлөгдөх зардалд үр дүнтэй хяналт хийх боломжийг хангах зорилгоор бүх зардлуудыг зардлын төвүүд болон тэдний дэд ангилалуудад хуваан ангилж, АМГТХЭГ-т танилцуулна.

Нарийвчилсан ангиллыг энэхүү Хавсралт Г-ийн 1.8 дүгээр зүйлийн дагуу тохиролцоно. Гэхдээ доорх ангилалууд заавал хийгдэнэ. Үүнд:

a) Талбай тус бүрээр зардлууд дараах маягаар хуваарилагдана:

1. Хайгуулын талбай.
2. Олборлолтын талбай нэг бүрчлэн.
3. Дамжуулах хоолой гэх мэт талбайн гадуур үйл ажиллагааны зардал.
4. Тодорхой талбайд хамааруулах боломжгүй зардлууд.

б) Газрын тосны үйл ажиллагаа бүрт зардлууд дараах маягаар хуваарилагдана:

i) Хайгуулын үйл ажиллагаа. Үүнд:

1. Агаар сансрын, геологийн, геохимийн, үе давхаргын, топографийн болон бусад судалгаа.
2. Чичирхийлэлийн судалгаа нэг бүрчлэн.
3. Хайгуулын болон үнэлгээний цооног нэг бүрчлэн.
4. Бусад машин, тоног төхөөрөмж, материал, сэлбэг хэрэгсэл болон холбогдох бусад анги, хэсгүүд
5. Дэд бүтэц (зам, нисэх онгоцны буудал).
6. Туслах байгууламжууд (агуулах гэх зэрэг). Эдгээрт ердийн үйлчилгээний өртөг хуваарилалт орно (Газрын тосны үйл ажиллагаатай холбогдох зардлууд).
7. Ерөнхий зардлууд болон Удирдлагын зардлын хуваарилалт.

8. Бусад зардлууд.

ii) Олборлолтын үйл ажиллагаа. Үүнд:

1. Агаар сансрын, геологийн, геохимийн, геофизикийн болон бусад судалгаа.
2. Олборлолтын цооног нэг бурчлэн.
3. Хуримтлуулах шугамууд.
4. Талбайн байгууламжууд.
5. Газрын тосны хадгалах байгууламжууд.
6. Дамжуулах хоолой, тээврийн цистернууд.
7. Бусад машин, тоног төхөөрөмж, материал, сэлбэг хэрэгсэл болон холбогдох бусад анги, хэсгүүд
8. Дэд бүтэц.
9. Туслах байгууламжууд (агуулах гэх зэрэг). Эдгээрт ердийн үйлчилгээний өртөг хуваарилалт орно (Газрын тосны үйл ажиллагаатай холбогдох зардлууд).
10. Ерөнхий зардлууд болон Удирдлагын зардлын хуваарилалт.
11. Хүү болон санхүүжилтийн зардлууд
12. Бусад зардлууд

iii) Ашиглалтын үйл ажиллагааг олборлолтын үйл ажиллагаатай адил ангилна.

5. НӨХӨН ТӨЛӨГДӨХГҮЙ ЗАРДЛУУД

Өртөгт тосыг тодорхойлох зорилгоор доорх зардлыг нөхөн төлөгдөхгүй зардалд тооцно. Үүнд:

- a) Бүртгэл байхгүй болон биет зүйлийн хувьд зөрчилтэй зардлууд.
- b) Осол, гамшгийн улмаас гарсан зардлаас бусад Гэрээлэгчийн худалдан авсан бараа, гүйцэтгүүлсэн болон захиалсан үйлчилгээний үнэ тухайн үсийн адил чанарын бараа үйлчилгээний олон улсын зах зээлийн үнэ, олон улсын зах зээлд давамгайлж буй нийлүүлэлтийн адилхан нөхцөлийн үнийн жишгээс илүү гарсан зардал.
- c) Туслан гүйцэтгэгч болон нийлүүлэгчтэй байгуулсан холбогдох Гэрээтэй үл нийцэх бараа, үйлчилгээний төлбөрүүд.
- d) Дээрх в хэсэгт заасны дагуу эд материалын байдал үнэтэйгээ таarahгүй нөхцөлд энэ зөрчилтэй холбогдон гарсан нэмэгдэл зардал.
- e) Газрын тосны үйл ажиллагаанд онцын шаардлагагүй зардал. Үүнд нийлүүлэх цэгээс хойш гарах үйл ажиллагааны, тухайлбал газрын түүхий тосыг Монгол Улсаас гаргахаар ачааны машин, вагон мэтийн тээврийн хэрэгсэлд ачсаны дараах зардал.
- f) Монгол Улсаас бусад улсад төлсөн орлогын болон бусад татварууд.
- g) Гэрээний 10 дугаар зүйлд заасны дагуу төлөгдөх урамшууллууд болон бусад төлборүүд.

- ж) Шүүгч, Арбитрч буюу шинжээч асуудлыг өөрөөр шийдвэрлээгүй бол Гэрээний 22 дугаар зүйлийн дагуу шүүх, арбитражийн болон шинжээчдийн зардал.
- з) Монгол Улсын Шүүх болон эрх бүхий бусад байгууллагаас ногдуулсан торгууль, анз.
- и) АМГТХЭГ-аас бичгээр зөвшөөрөгдөөгүй ажил үйлчилгээ, аливаа хандив, тусlamж.
- й) Энд 1(о)-д тусгагдсан хайгуулын үйл ажиллагаатай холбогдсон зээлийн хүү болон санхүүжилтийн зардлууд.
- к) Газрын тос хайх, олборлох, ашиглахад зориулсан шинэ тоног төхөөрөмж, материал болон аргачлал, үйлдвэрлэлд нэвтрүүлэх зорилгоор судалгаа хийхтэй холбогдон гарсан зардал.
- л) Газрын түрээсийн төлбөр.

6. АВЛАГА ЗАРЛАГЫН ДАВХАРДАЛТ

Бүртгэл тооцооны журмыг үл зөрчиж, Гэрээнд хамаарах данснуудын авлага зарлагыг давхардуулахгүй байх ёстой.

ГУРАВДУГААР ЗҮЙЛ ТООЛЛОГО БОЛОН ТООЛЛОГЫН ТАЙЛАН

1. ТОГТМОЛ ТООЛЛОГО ХИЙХ, МЭДЭГДЭХ БОЛОН ТӨЛӨӨЛӨХ

АМГТХЭГ болон Гэрээлэгч харилцан тохиролцож тогтоосон зохих хугацаанд Гэрээлэгч үйл ажиллагааны бүх эд материал, бист хөрөнгө болон барилга угсралтын төслүүдийн тооллогыг явуулж байна.

Тооллогод АМГТХЭГ оролцох боломжийг хангах үүдиэс Гэрээлэгч тооллого эхлэхээс гuchaас (30) доoshgүй хоногийн өмнө тооллого хийх тухай АМГТХЭГ-т бичгээр мэдэгдэнэ. Ийнхүү мэдэгдсэний дараа АМГТХЭГ-ын томилсон төлөөлөгч тооллогод оролцох үүргээ биелүүлээгүй тохиолдолд Гэрээлэгчийн дангаараа хийсэн тооллогыг хүчинтэйд тооцно. Гэрээлэгч жил бүр доод тал нь нэг удаа, мөн Гэрээг цуцлах тохиолдолд тооллого явуулна.

2. ТООЛЛОГЫН БҮРТГЭЛИЙГ ТУЛГАН ШАЛГАЖ, ЗОХИЦУУЛАХ ТУХАЙ

Гэрээлэгч, АМГТХЭГ хоёр хамтран эд хөрөнгийн тооллогын бүртгэлийг тулган шалгаад, илүүдэл буюу дуталтын жагсаалтыг гаргаж, Гэрээлэгч нь зөрүүг залруулна.

3. ТООЛЛОГЫН ТАЙЛАН

- а) Гэрээлэгч нь олон улсын газрын тосны салбарын нягтлан бодох бүртгэлийн жишигийн дагуу газрын тосны үйл ажиллагаанд хэрэглэгдэж буй өд хоронгийн нарийвчилсан бүртгэл хийнэ.

6) Гэрээлэгч нь доорх зүйлүүдийг агуулсан тооллогын тайланг АМГТХЭГ-т улирал тутамд ирүүлнэ. Үүнд:

1. Хянах боломжтой бүх эд хөрөнгө, материалын тодорхойлолт болон код.
2. Эд хөрөнгө тус бүрийн дансанд бүртгэгдсэн үнийн дун.
3. Эд хөрөнгийг дансанд бүртгэсэн он, сар, өдөр.
4. Эдгээр эд хөрөнгийн өртөг Гэрээний 8 дугаар зүйлийн дагуу нехөгдсөн эсэх.

ДӨРӨВДҮГЭЭР ЗҮЙЛ

ОЛБОРЛОЛТЫГ ХЭМЖИХ БА ОЛБОРЛОЛТЫН ТАЙЛАН

1. Олборлолтын тайланг доорх зарчмуудын дагуу бэлтгэнэ. Үүнд:

- a) Гэрээний VIII, IX зүйлд заасны дагуу хуваах тос ба өртөгт тосыг гэрээт талбайгаас олборлосон болон хадгалсан нийт түүхий тосны хэмжээг үндэслэн тодорхойлно.
- b) Өдөрт олборлосон түүхий тосны хэмжээг Гэрээний 8 дугаар зүйлд заасны дагуу тодорхойлно. Бүтээгдэхүүн хуваах цэг(үүд)-ээр зэрэглэлийн хувьд ялгаатай түүхий тос ирж байвал зэрэглэл тус бүрээр хэмжээг нь тодорхойлно.
- c) Олборлосон хийгээд неөцелсөн түүхий тос болон хийн нийт хэмжээг Олборлолтын талбай дахь ачих цэгт өдөр бүр тодорхойлно. Уг талбайн ачих цэгт олон төрлийн зэрэглэл бүхий түүхий тосыг юулэх бөгөөд ийм түүхий тосны зэрэглэлийг АМГТХЭГ, Гэрээлэгчийн хооронд хэлэлцэн тохигоогүй бол тус бүрчлэн ангилан тогтооно. Ачих цэг нь Олборлолтын талбайд байх агаад дамжуулах хоолой, төмер зам, машинаар Олборлолтын талбайгаас тээвэрлэхээс өмнө энэ цэгт түүхий тосыг хэмжиж тодорхойлно.
- d) Түүхий тосны хэмжээг хэвийн температур, даралтад байхад нь тодорхойлох ба агуулах усны хэмжээ, тунамал хурдасны байдлаас шалтгаалан засвар оруулна. Түүхий тосны нягт, хүхрийн агууламж болон бусад чанарын тодорхойлтуудыг тогтмол шалгаж, бүртгэж байх ёстой.
- e) Байгалийн хийн хэмжээг хэвийн температур болон даралтад байхад нь тодорхойлно. Дулаан ялгаруулах чадвар (калорийность), хүхрийн агууламж болон бусад чанарын тодорхойлолтуудыг тогтмол шалгаж, бүртгэж байна.
- f) Газрын тосны үйл ажиллагаанд зарцуулсан түүхий тос, байгалийн хийн хэмжээг өдөр болгон хэмжиж, бүртгэж байна. Эдгээр нь:
 - I. дахин шахах;
 - II. дахин боловсруулах;
 - III. хайгуул, олборлолтын болон дамжуулах хоолойд шахаад шаардагдах гэх мэт талбайн үйл ажиллагааны эрчим хүчиний хэрэглээнд зарсан.
- g) Шатаасан буюу ууршсан түүхий тос, байгалийн хийг өдөр болгон бүртгэнэ.
- h) Түүхий тосны болжи нөөцийн хэмжээг хуанилийн сар бүрийн эхэн, эцэст хамгийн багаар нь тооцож тогтоосон байна.

2. Тухайн цооног ба талбайгаас анхны эдийн засгийн үр ашигтай олборлолт эхэлмэгц олборлолтын талбай бүрээр доор заасан мэдээллүүдийг багтаасан олборлолтын тайланг Гэрээлэгч сар бүр гаргаж өгнө. Үүнд:

- a) Олборлож, хадгалсан түүхий тосны хэмжээ
- б) Олборлож, хадгалсан байгалийн хийн хэмжээ
- в) Өрөмдлөг явуулах, олборлох болон хадгалах сав уруу шахаад ашигласан түүхий тосны хэмжээ
- г) Ууршуулсан байгалийн хийн хэмжээ
- д) Сарын эхний түүхий тосны нөөцийн хэмжээ
- е) Сарын эцсийн түүхий тосны нөөцийн хэмжээ

ТАВДУГААР ЗҮЙЛ

ОЛБОРЛОЛТЫН ТАЙЛАНГИЙН ҮНЭЛГЭЭ

1. Гэрээлэгч нь хуанлийн улирал бүр энэхүү Гэрээний дагуу олборлож, борлуулсан түүхий тосны үнэлгээг тооцоолсон тайланг бэлтгэх ёстой. Олборлолтын тайлангийн үнэлгээ нь дараах зүйлүүдийг агуулна. Үүнд:

- a) АМГТХЭГ ба Гэрээлэгчээс баримтжуулсан тухайн хуанлийн улирлын турш гуравдагч этгээдэд борлуулсан түүхий тосны хэмжээ, үнэ
- б) АМГТХЭГ ба Гэрээлэгчээс баримтжуулсан тухайн хуанлийн улирлын турш гуравдагч этгээдээс өөр этгээдэд борлуулсан түүхий тосны хэмжээ, үнэ
- в) Гэрээний 8.5 зүйл хамарагдах тохиолдолд түүхий тосны үнэлгээ тогтоох зорилгоор газрын тос экспортлогч гол гол орнуудын түүхий тосны үнэлгээний талаарх боломжтой мэдээлэл /Гэрээний үнэ, хөнгөлөлт, урамшуулал, үнийн талаарх мэдээллийг багтаасан/

ЗУРГААДУГААР ЗҮЙЛ

ӨРТӨГ НӨХӨЛТИЙН ТАЙЛАН

1. Гэрээлэгч нь үүргийнхээ дагуу хуанлийн улирал бүр дорх зүйлүүдийг агуулсан өртөг нөхөлтийн тайлан бэлтгэх ёстой. Үүнд:

- а) Өмнөх хуанлийн улирлаас үлдсэн өртөг нөхөгдөх зардал;
- б) Тухайн хуанлийн улиралд гарсан өртөг нөхөгдөх зардал;
- в) Тухайн хуанлийн улиралд нөхөж авах нийт зардал;
- г) Хуанлийн улирлын туршид Гэрээлэгчийн авсан өртөгт тосны хэмжээ, үнэ
- д) Хуанлийн улиралд өртөг нөхсөн зардлын хэмжээ;
- е) Дараагийн хуанлийн улиралд шилжүүлсэн өртөг нөхөгдөх зардал;

2. ХЯАЛТЫН ТАЙЛАНГУУД

Гэрээлэгч нь өртөг нөхөлтийн данс ба тэнцүүлэх серөг данс нээж нөхөгдөх зардлын үлдэж буй хэмжээ, нөхөгдсөн хэмжээг хянах бөгөөд энэ дансны мэдээллийг улирал бүр АМГТХЭГ-т гаргаж өгнө.

ДОЛДУГААР ЗҮЙЛ

ОРЛОГО ЗАРЛАГЫН ТАЙЛАН

Гэрээлэгч нь үүргийнхээ дагуу хуанлийн улирал бүр орлого зарлагын тайланг гаргаж өгнө. Энэ тайлан нь дараах зүйлүүдийг тусгасан байна. Үүнд:

- а) Энэхүү Бүртгэл тооцооны журамд тохирсон зардлын ангиалал ба зардлын төвд үндэслэн, төсөвт тусгах хуанлийн жилийн орлого, зарлага;
- б) Энэхүү Гэрээний дагуу нөхөгдөх зардал гэж тогтоосон, тухайн хуанлийн улиралд хуримтлагдсан орлого ба зарлага;
- в) Хараахан шийдвэрлээгүй байгаа хуанлийн жилийн хуримтлагдсан орлого ба зарлага;
- г) Төсөвт оруулах Гэрээний дагуу зөвшөөрсөн өөрчлөлтүүд;
- д) Жилийн эцсийн хуримтлагдсан орлого ба зарлагын урьдчилсан тооцоо;
- е) Дээрх (г) зүйлийн дагуу засварласан төсөв ба урьдчилсан тооцооны хоорондын ялгаа, тайлбар.

НАЙМДУГААР ЗҮЙЛ

АШИГТ ТОС БА ТЭНЦВЭРЖҮҮЛЭЛТИЙН ТАЙЛАН

Гэрээлэгч ашигт тос ба тэнцвэржүүлэлтийн тайланг улирал бүр бэлтгэнэ. Үүнд:

- а) Тухайн улирлын турш олборлосон Түүхий тос;
- б) Тухайн улирлын эцэст олборлон хуримтлагдсан Түүхий тос;
- в) Тухайн улиралд АМГТХЭГ ба Гэрээлэгчид ногдох Ашигт тос,
- г) Тухайн улирлын эцэст АМГТХЭГ ба Гэрээлэгчид ногдох Ашигт тосны хуримтлагдсан нийт хэмжээ;
- д) Тухайн улиралд Гэрээлэгчийн авах Өртөгт тосны хэмжээ;
- е) Тухайн улирлын эцэст Гэрээлэгчийн авах Өртөгт тосны хуримтлагдсан хэмжээ;
- ё) Тухайн улиралд АМГТХЭГ ба Гэрээлэгчийн хийх тэнцвэржүүлэлтүүд;
- ж) Тухайн улирлын эцэст АМГТХЭГ ба Гэрээлэгчийн хийх хуримтлагдсан тэнцвэржүүлэлтүүд;
- з) Тухайн улирлын эцэст АМГТХЭГ ба Гэрээлэгчийн хийх илүүдэл буюу дутсаныг тэнцвэржүүлэх тайлан.



60

ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ
АГЕНТЛАГ ГАЗРЫН ТОСНЫ ГАЗРЫН
ДАРГА Д АМАРСАЙХАН ТАНАА

МОНГОЛ УЛСЫН
ЭРДӨС БАЯЛГААГ ЭРЧИМН ХҮЧИНН
САЙД

15160 Уланбаатар хотын Цагдаагийн дүүрэг
Нийдэлийн түүрэлжийн судалгаа №1, Чөлөөний сүрьеийн баяр
Улаан, Засгийн төхөн, 1976-11-27 г.

100367/1 № 14927
танийн №

Хайгуулын үйл ажиллагааг сэргээх тухай

Үйлдвэр, худалдааны сайдын /хуучин нэрээр/ 2008 оны 03 дугаар сарын 24-ний өдрийн 1/911 албан тоотоор газрын тосны хайгуулын Нялга- XVI талбайд үйл ажиллагаа явуулж байсан "Шэйман" ХХК-ний хайгуулын ажлыг "Хэрлэнгийн хөдөө зэрл"-д гүйцэтгэхийг түр хугацаагаар түдгэлзүүлсэн

"Шэйман" ХХК-аас 2009 оны 04 дүгээр сарын 08-ны өдрийн 20/09 тоотоор ирүүлсэн хүснэгт Газрын тосны газрын 2009 оны 04 дүгээр сарын 13-ны өдрийн 1/176 албан тоот зэргийг үндэслэн "Хэрлэнгийн хөдөө зэрл"-ын нутаг дэвсгэрт орших 2710 газар дээр км талбайгаас гадна, хайгуулын талбайн хэмжээнд хамаарах Хэрлэн голын баруун болон ёмнөд хэсэгт хайгуулын үйл ажиллагаа: сэргээн явуулах талаар тус компанийд танай газар мэдэгдэх нь зүйтэй.



60

ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ
АГЕНТЛАГ ГАЗРЫН ТОСНЫ ГАЗРЫН
ДАРГА Д АМАРСАЙХАН ТАНАА

МОНГОЛ УЛСЫН
ЭРДӨС БАЯЛГААГ ЭРЧИМН ХҮЧИНН
САЙД

15160 Уланбаатар хотын Цагдаагийн дарга
Нийдэлийн түүрэлжийн судалгаа №1, Чөлөөний сүрьеийн баяр
Улаан, Засгийн төхөн, 1976-11-27 г.

100367/1 № 14927
танийн №

Хайгуулын үйл ажиллагааг сэргээх тухай

Үйлдвэр, худалдааны сайдын /хуучин нэрээр/ 2008 оны 03 дугаар сарын 24-ний өдрийн 1/911 албан тоотоор газрын тосны хайгуулын Нялга- XVI талбайд үйл ажиллагаа явуулж байсан "Шэйман" ХХК-ний хайгуулын ажлыг "Хэрлэнгийн хөдөө зэрл"-д гүйцэтгэхийг түр хугацаагаар түдгэлзүүлсэн

Шэйман ХХК-аас 2009 оны 04 дүгээр сарын 08-ны өдрийн 20/09 тоотоор ирүүлсэн хүснэгт Газрын тосны газрын 2009 оны 04 дүгээр сарын 13-ны өдрийн 1/176 албан тоот зэргийг үндэслэн "Хэрлэнгийн хөдөө зэрл"-ын нутаг дэвсгэрт орших 2710 газар дээр км талбайгаас гадна, хайгуулын талбайн хэмжээнд хамаарах Хэрлэн голын баруун болон ёмнөд хэсэгт хайгуулын үйл ажиллагааг сэргээн явуулах талаар тус компанийд танай газар мэдэгдэх нь зүйтэй.

ЭХ СУРВАЛЖ: WWW.ILTODGEREE.MN



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2007 оны 6 дугаар
сарын 20-ны өдөр

Дугаар 148

Улаанбаатар
хот

Бүтээгдэхүүн хуваах гэрээ
батлах тухай

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

Газрын тосны хайгуулын Нялга-ХҮІ талбайд газрын тостой холбогдсон уйл ажиллагаа явуулах талаар Ашигт малтмал, газрын тосны хэрэг эрхлэх газар, Канад Улсын "Шаман Ресурсес" компанийн хооронд 2007 оны 4 дүгээр сарын 18-ны өдөр байгуулсан Бүтээгдэхүүн хуваах гэрээг баталсугай.

Монгол Улсын Ерөнхий сайд

М.ЭНХБОЛД

Үйлдвэр, худалдааны сайд

Ц.ДАВААДОРЖ

ЭХ СУРВАЛЖ: WWW.ILTODGEREE.MN



МОНГОЛ УЛСЫН
ҮНДЭСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН
ЗӨВЛӨЛИЙН ХУРАЛДЛАНЫ
ТЭМДЭГЛЭЛ

2006 оны 11 сарын 20-өдөр

Дугаар 18/12

Улсынбэлээр хот

Бүтээгдэхүүн хуваах гэрээ байгуулах тухай

Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын Зөвлөлийн хуралдаанаар “Бүтээгдэхүүн хуваах гэрээ байгуулах тухай” Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Үйлдвэр худалдааны сайд Б.Жаргалсайханы илтгэлийг хэлэлцээд шийдвэрлэсэн нь:

Монгол Улсын Засгийн газарт:

Нэг. Канад Улсын “Шаман Ресурсс” компанитай газрын тосны хайгуулын Нялти-ХҮ талбайд байгуулах бүтээгдэхүүн хуваах гэрээний үндсэн нөхцөл нь БНХАУ-ын “Чайна Голден Сий Петролиум Эксплорейшн Корпорэйши” компанитай газрын тосны хайгуулын Тариач-ХҮ талбайд байгуулах бүтээгдэхүүн хуваах гэрээний үндсэн нөхцөлөөс хэт доогуур байгааг шалгаж, жишигт нийцүүлэх арга хэмжээ авах;

Хоёр. Бүтээгдэхүүн хуваах гэрээ байгуулж буй компаниуд гэрээгүүсэхэд хүчлийн эрх үүргээ бусдад шилжүүлэх нөхцөлийг хязгаартай, тодорхой болгох асуудлыг хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох ажлын хүрээнд хамгатган авч үзэх;

Гурав. Газрын тосны хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгох асуудлаар санал боловсруулж, хэлэлцүүлэхийг тус тус даалгав.

ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ТАМГЫН
ГАЗРЫН ДАРГА

T. БИЛЭГТ

ЭХ СУРВАЛЖ: WWW.ILTODGEREE.MN



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙДЫН ЗАХИРАМЖ

2007 оны 4 дүгээр
сарын 11-ний өдөр

Дугаар 33

Улаанбаатар
хот

Бүтээгдэхүүн хуваах гэрээ
байгуулах тухай

Газрын тосны хайгуулын НЯЛГА-XVI талбайд газрын тостой холбогдсон уйл ажиллагаа явуулах талаар Ашигт малтмал, газрын тосны хэрэг эрхлэх газар, Канад Улсын "Шаман Ресурсес" компанийн хооронд байгуулах Бүтээгдэхүүн хуваах гэрээнд гарын усэг зурахыг Ашигт малтмал, газрын тосны хэрэг эрхлэх газрын дарга (Л.БОЛД)-д зөвшөөрсүгэй.

Монгол Улсын Ерөнхий сайд

М.ЭНХБОЛД

ЭХ СУРВАЛЖ: WWW.ILTODGEREE.MN